



ADB

# Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги

---

2021 оны 8-р сар

Монгол Улс  
2021–2024

“Хүртээмжтэй, тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх нь”

Энэхүү баримт бичгийг Захирлуудын зөвлөлөөс зөвшөөрөл өгөхөөс өмнө нийтэд түгээхийг хориглоно. АХБ-наас энэхүү баримт бичгийг нийтлэхдээ өөрийн Мэдээллийн хүртээмжийн бодлогыг даган мөрдөнө.



## ВАЛЮТЫН ХАНШ

(2021 оны 7-р сарын 19-ний өдрийн байдлаар)

Валютын нэгж	–	төгрөг (Монгол төгрөг)
1.00 төгрөг	=	0.00035102 ам.доллар
1.00 ам.доллар	=	2, 848.85 төгрөг

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АХБ	–	Азийн Хөгжлийн Банк
КОВИД-19	–	коронавирусээр үүсгэгдэх өвчин
ХТС	–	хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги
ИНБ	–	иргэний нийгмийн байгууллага
ДНБ	–	дотоодын нийт бүтээгдэхүүн
ХБҮГ	–	Хараат бус үнэлгээний газар
ХХҮАГ	–	Хувийн хэвшлийн үйл ажиллагааны газар
ЕХЭҮ	–	Ердийн хөрөнгийн эх үүсвэр
ҮТЗ	–	Үйл ажиллагааны тэргүүлэх зорилт
БСЗ	–	бодлогод суурилсан зээл
ТХХТ	–	төр, хувийн хэвшлийн түншлэл
ЖДҮ	–	жижиг, дунд үйлдвэр
ТТ	–	техникийн туслалцаа

## ТЭМДЭГЛЭЛ

- (i) Энэхүү тайланд “\$” тэмдгийг ам.доллар гэнэ.

## ТАЙЛБАР

<i>аймаг</i>	–	засаг захиргааны нэгж
<i>зуд</i>	–	орон нутагт тохиолдох байгалийн гамшиг (өвөлжилтийн хүнд нөхцөл байдал)
<i>гэр</i>	–	уламжлалт сууц

<p><b>Дэд ерөнхийлөгч</b> <b>Ерөнхий захирал</b> <b>Захирал</b> <b>Багийн ахлагчид</b></p>	<p>Ахмед М. Сайед, Үйл ажиллагааны групп 2 М. Тереза Кхо, Зүүн Азийн газар (ЗАГ) Павит Рамачандран, Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газар (МСТГ), ЗАГ Цолмон Бэгзсүрэн, Нийгмийн хөгжил, жөндөрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ</p>
<p><b>Багийн гишүүд</b></p>	<p>Деклан Ф. Маги, Тэргүүлэх эдийн засагч, МСТГ, ЗАГ Эдуардо Абелло, Үйл ажиллагааны зохицуулалт хариуцсан тэргүүлэх мэргэжилтэн, Ерөнхий захирлын ажлын алба (ЕЗАА), Хувийн хэвшлийн үйл ажиллагааны газар (ХХҮАГ) Бо Ань, Төрийн удирдлага хариуцсан мэргэжилтэн, Төрийн удирдлага, санхүүгийн салбар ба бүсийн хамтын ажиллагааны хэлтэс (ТУССБХАХ), ЗАГ Учралт Адьяахүү, Үйл ажиллагааны туслах ажилтан, МСТГ, ЗАГ Туул Бадарч, Дэд бүтцийн салбарын ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ Жие Бай, Хот байгуулалтын мэргэжилтэн, Хот, нийгмийн салбарын хэлтэс (ХНСХ), ЗАГ Даваадорж Батсайхан, Мэдээллийн технологийн туслах ажилтан, МСТГ, ЗАГ Мөнхтуяа Баянмөнх, Санхүүгийн албаны туслах зохицуулагч, МСТГ, ЗАГ Марк Р.Безуйжен, Байгаль орчны ахлах мэргэжилтэн, Захирал, Байгаль орчин, байгалийн баялаг, хөдөө аж ахуйн хэлтэс (БОББХААХ), ЗАГ Тэлмэн Билэгт, Үйл ажиллагааны ахлах туслах ажилтан, МСТГ, ЗАГ Мария Кармела Бүэнсалидо, Үйл ажиллагааны ахлах ажилтан, ЕЗАА, ХХҮАГ Мэри Жэйн Карангал-Сан Хосе, Мэдлэгийн дэмжлэг ба үйлчилгээний ахлах ажилтан, Мэдлэгийн зөвлөх үйлчилгээний төв (МЗҮТ), Тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн газар (ТХУАӨГ) Сильвиа Кардашиа, Залуу мэргэжилтэн, БОББХААХ, ЗАГ Николас Кастелли, Тээврийн ахлах мэргэжилтэн, Тогтвортой дэд бүтцийн хэлтэс (ТДБХ), ЗАГ София Норийн С.Кастийо-Плаза, Мэдлэгийн менежментийн ажилтан, ЕЗАА, ЗАГ Зиньцьень Чэнь, Хот байгуулалтын мэргэжилтэн (уур амьсгалын өөрчлөлтийн асуудал), ХНСХ, ЗАГ Анжелита М.Кортес, Үр дүнгийн удирдлагын ажилтан, Үр дүнгийн удирдлага ба Тусламжийн үр нөлөөг хянах хэлтэс (ҮДУТҮНХХ), Стратеги, бодлого ба түншлэлийн газар (СБТГ) Шэннон Каулин, Эрчим хүчний тэргүүлэх мэргэжилтэн, ТДБХ, ЗАГ Өнөржаргал Далайхүү, Бүсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн, МСТГ, ЗАГ Моника Ф.Димаано, Үйл ажиллагааны ахлах туслах ажилтан, ЕЗАА, ЗАГ Марга К.Доминго-Моралес, Үр дүнгийн менежментийн ахлах ажилтан, ЕЗАА, ЗАГ Жудит Б.Дончилло, Төсөл, хөтөлбөрийн удирдлагын ахлах ажилтан, ЗАГ Батцэрэн Энхбаатар, Үйл ажиллагааны туслах ажилтан, МСТГ, ЗАГ Энэрэлт Энхболд, Хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ Минюань Фань, Усны нөөцийн тэргүүлэх мэргэжилтэн, БОББХААХ, ЗАГ Жерард Эмил В.Гадияно, Хөтөлбөрийн туслах шинжээч, ЗАГ Сяоцинь Фань, Захирал, ТУССБХАХ, ЗАГ Ананд Ганбаатар, Тээврийн мэргэжилтэн, МСТГ, ЗАГ Гантуяа Ганхуяг, Үйл ажиллагааны туслах ажилтан, МСТГ, ЗАГ Гантуяа Ганзориг, Гадаад харилцааны ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ Абигэйл Д.Гарровийяс, Үйл ажиллагааны ахлах ажилтан, ЕЗАА, ЗАГ Аннабель Жиоржетти, Байгаль орчны эдийн засагч, БОББХААХ, ЗАГ Сангей Гровер, Төр-хувийн хэвшлийн түншлэлийн мэргэжилтэн, ТХХТГ Дунмэй Гуо, Байгаль орчны мэргэжилтэн, БОББХААХ, ЗАГ Сүжата Гүпта, Захирал, ТДБХ, ЗАГ Нажибулла Хабиб, Эрүүл мэндийн мэргэжилтэн, ХНСХ, ЗАГ Акико Терада-Хагвара, Тэргүүлэх эдийн засагч, ЗАГ Азиз Хайдаров, Санхүүгийн салбарын ахлах мэргэжилтэн, ТУССБХАХ Арно Хэкманн, Хот байгуулалтын тэргүүлэх мэргэжилтэн, ХНСХ, ЗАГ Маттиас Хэлбл, Эдийн засагч, Бүсийн хамтын ажиллагаа, интеграцчиллын хэлтэс, Эдийн засгийн судалгаа, бүсийн хамтын ажиллагааны газар Ян Хинрикс, Байгалийн баялгийн ахлах эдийн засагч, БОББХААХ, ЗАГ</p>

Бяо Хуан, Хөрөнгө оруулалтын тэргүүлэх мэргэжилтэн, Санхүүгийн байгууллагын хэлтэс, ХХҮАГ  
Батцэнгэл Жамсранжав, Худалдан авалтын ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ  
Алтантуяа Жигжидсүрэн, Нийгмийн салбарын ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ  
Вероника Жофре, Нийгмийн хөгжлийн мэргэжилтэн (жөндөр ба хөгжлийн асуудал), ЕЗАА, ЗАГ  
Нана Хуродзе, Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, Хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагын хэлтэс, ХХҮАГ  
Хисака Кимура, Зөвлөх, ЕЗАА, ХХҮАГ  
Жунносүке Кобаяши, Хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтэн, ЕЗАА, ХХҮАГ  
Ёшияки Кобаяши, Усны нөөцийн тэргүүлэх мэргэжилтэн, БОББХААХ, ЗАГ  
Доротея Лазаро, Бүсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн, ТУССБХАХ, ЗАГ  
Мари Мишель С.Либүн, Төслийн шинжээч, ЕЗАА, ЗАГ  
Хайди П.Лозари, Байгууллагын зохицуулалтын ахлах мэргэжилтэн, ЕЗАА, ЗАГ  
Сян Ли, Хөрөнгө оруулалтын ахлах ажилтан, Дэд бүтцийн санхүүжилтийн хэлтэс 2 (ДБСХ2), ХХҮАГ  
Итгэл Лонжид, Нийгмийн салбарын ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ  
Мальте Маасс, Уур амьсгалын өөрчлөлтийн мэргэжилтэн, Уур амьсгалын өөрчлөлт ба гамшгийн эрсдэлийн удирдлагын хэлтэс, ТХУАӨГ  
Жеффри М.Миллер, Тээврийн тэргүүлэх мэргэжилтэн, ТДБХ, ЗАГ  
Хуан-Пабло Мартинез-Молина Меркадо, Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, ХХҮАГ  
Эдит Жойи Накпил, Эдийн засгийн ахлах ажилтан, ТУССБХАХ, ЗАГ  
Смита Лутра Нахүда, Үр дүнгийн удирдлагын ахлах мэргэжилтэн, ҮДҮТҮНХХ, СБТГ  
Жаяти Нигам, Эрүүл мэндийн мэргэжилтэн, ХНСХ, ЗАГ  
Роузмери К.Он, Төр-хувийн хэвшлийн түншлэлийн ахлах мэргэжилтэн, Зөвлөх үйлчилгээний хэлтэс 2 (ЗҮХ2), Төр-хувийн хэвшлийн түншлэлийн газар (ТХХТГ)  
Рабиндра Ости, Усны нөөцийн ахлах мэргэжилтэн, БОББХААХ, ЗАГ  
Томас Панелла, Захирал, БОББХААХ, ЗАГ  
Сангей Пенжор, Захирал, ХНСХ, ЗАГ  
Онгонсар Пүрэв, Байгаль орчны ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ  
Айша Кадир, Хуулийн ерөнхий зөвлөх, Хуулийн алба  
Висванатан Рамасубраманиян, Хамгааллын ахлах мэргэжилтэн (нүүлгэн шилжүүлэлтийн асуудал), ХНСХ, ЗАГ  
Вивек Раман, Үйл ажиллагааны зохицуулалтын ахлан мэргэжилтэн (инноваци ба мэдлэгийн асуудал), МЗҮТ, ТХУАӨГ  
Линдси Мари Рено, Үр дүнгийн удирдлагын мэргэжилтэн, ҮДҮТҮНХХ, СБТГ  
Ханс ван Рийн, Төрийн удирдлагын тэргүүлэх мэргэжилтэн, ТУССБХАХ, ЗАГ  
Сюзанн Робертсон, Байгаль орчны тэргүүлэх мэргэжилтэн, Байгаль орчны сэдэвчилсэн ажлын хэсэг, ТХУАӨГ  
Женнифер Ромеро-Торрес, Санхүүгийн салбарын ахлах мэргэжилтэн, ТУССБХАХ, ЗАГ  
Болд Сандагдорж, Эдийн засгийн ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ  
Ацумаса Сакай, Эрчим хүчний ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ  
Карин Шелциг, Нийгмийн салбарын тэргүүлэх мэргэжилтэн, ХНСХ, ЗАГ  
Сиддарта Шах, Захирал, ЗҮХ2, ТХХТГ  
Ребекка Стэйплтон, Тээврийн мэргэжилтэн, ТДБХ, ЗАГ  
Оюунчимэг Сүрэн, Санхүү, захиргааны ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ  
Гохар Тадевосян, Нийгмийн хөгжлийн ахлах мэргэжилтэн (хамгааллын асуудал), ХНСХ, ЗАГ  
Эйсүке Тажима, Боловсролын тэргүүлэх мэргэжилтэн, Төв ба Баруун Азийн бүсийн газар (ТБАБГ)  
Юмико Тамура, Үйл ажиллагааны зохицуулалтын тэргүүлэх мэргэжилтэн, ЕЗАА, ЗАГ  
Дипак Танежа, Хөрөнгө зохицуулалтын тэргүүлэх мэргэжилтэн, Хөрөнгө зохицуулалтын газар  
Мукия Тиручелвам, Төсөл, хөтөлбөрийн удирдлагын ахлах мэргэжилтэн, МСТГ, ЗАГ

**Хянасан**

Хьет Т. Х. Тран, Худалдан авалтын ахлах мэргэжилтэн, Худалдан авалтын хэлтэс  
2, Худалдан авалт, төсөл, хөтөлбөр ба санхүүгийн удирдлагын газар  
Золзаяа Цэцэгчимэг, Үйл ажиллагааны туслах ажилтан, МСТГ, ЗАГ  
Ажнай Цогбаясгалан, Мэдээллийн технологийн ахлах ажилтан, МСТГ, ЗАГ  
Энхцацрал Өлзий-Орших, Үйл ажиллагааны туслах ажилтан, МСТГ, ЗАГ  
Анжель П.Вега-Росал, Нарийн бичгийн дарга, ЗАГ  
Сяолэ Ван, Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, ЕЗАА, ХХҮАГ  
Шигеру Ямамура, Төсөл, хөтөлбөрийн удирдлагын тэргүүлэх мэргэжилтэн, ЕЗАА,  
ЗАГ  
Цинфэн Жан, Ахлагч, Хөдөөгийн хөгжил ба хүнсний аюулгүй байдал (хөдөө аж  
ахуй) сэдэвчилсэн ажлын хэсэг, ТХУАӨГ  
Ражеш Васудеван, Ахлах эдийн засагч, Бүс нутгийн хамтын ажиллагаа ба үйл  
ажиллагааны зохицуулалтын хэлтэс, ТБАБГ  
Венди Уолкер, Ахлагч, Нийгмийн хөгжлийн сэдэвчилсэн ажлын хэсэг, ТХУАӨГ

Аливаа улс оронтой хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийг боловсруулж, төслийг санхүүжүүлэхдээ, эсвэл энэхүү баримт бичигт тодорхой нэг газар нутаг, газар зүйн бүсийг онцлон дурьдахдаа Азийн Хөгжлийн Банк нь тухайн газар нутаг, эсвэл бүс нутгийн хууль эрх зүйн болоод бусад статусыг ямар нэг хэлбэрээр хөндөх зорилго агуулаагүй болно.

## ГАРЧИГ

	Хуудас
МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ	
I. ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ГОЛ АГУУЛГА	1
II. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	2
III. ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	8
A. Өмнөх стратегиас авсан сургамжууд	8
Б. Үндэсний хөгжлийн стратеги	8
В. Хөгжлийн түншүүдийн гүйцэтгэх үүрэг	9
Г. АХБ-ны стратегийн болон сэдэвчилсэн зорилтууд, төрийн сектор болон хувийн хэвшилд хамаарах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл	9
Д. Мэдлэгийг шилжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл	18
IV. СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТ	18
A. Хөрөнгийн ерөнхий тойм үзүүлэлт	18
Б. Хэрэгжилтийн явцад анхаарах асуудлууд	18
В. Үр дүнгийн хяналт	19
Г. Тулгарч болзошгүй эрсдэлүүд	19
ХАВСРАЛТ	
1. Түншлэлийн стратегийн үр дүнгийн матриц	21
2. Монгол Улсад хэрэгжүүлэх мэдлэг шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	25
3. Холбоосоор хавсаргах баримтын жагсаалт	30





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ

<b>Эдийн засгийн үзүүлэлтүүд<sup>а</sup></b>	<b>2016</b>	<b>2017</b>	<b>2018</b>	<b>2019</b>	<b>2020</b>
ДНБ (тэрбум \$, оны үнээр)	11.2	11.4	13.1	14.0	13.1
Нэг хүнд ногдох ДНБ (\$, оны үнээр)	3,578.0	3,596.1	4,047.6	4,245.2	3,915.0
Нэг хүнд ногдох ҮНО (\$, атлас аргачлалаар)	3,465.0	3,195.0	3,579.0	3,743.0	3,678.0
ДНБ-ийн өсөлт (% , зэрэгцүүлсэн үнээр)	1.2	5.3	7.2	5.2	(5.3)
Уул уурхайн ДНБ-ийн өсөлт (% , зэрэгцүүлсэн үнээр)	0.2	(5.5)	6.1	(0.4)	(9.4)
Уул уурхайн бус ДНБ-ийн өсөлт (% , зэрэгцүүлсэн үнээр)	1.5	8.9	7.6	6.7	(4.3)
Хөдөө аж ахуй	6.2	1.8	4.5	8.4	6.2
Аж үйлдвэр (уул уурхайгаас бусад)	(2.4)	16.7	11.7	9.9	(1.6)
Үйлчилгээ	1.2	8.0	5.1	5.8	(7.2)
Дотоодын нийт хөрөнгө оруулалт (ДНБ-д эзлэх хувь)	25.7	31.4	39.6	39.4	24.3
Дотоодын нийт хуримтлал (ДНБ-д эзлэх хувь)	30.5	33.7	34.0	33.4	28.7
Хэрэглээний үнийн индекс (жилийн өөрчлөлт, %-аар)	1.3	6.4	8.1	5.2	2.3
Мөнгөний нийлүүлэлт (M2) (жилийн өөрчлөлт, %-аар)	21.0	30.5	22.8	7.0	16.3
Төсвийн нийт ашиг (алдагдал) (ДНБ-д эзлэх хувь)	(15.3)	(3.8)	2.6	1.4	(9.6)
Гадаад худалдааны тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	12.0	13.1	5.2	8.3	13.5
Урсгал тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	(6.3)	(10.1)	(16.8)	(15.4)	(5.1)
Гадаад өрийн үйлчилгээ (бараа, үйлчилгээний экспортод эзлэх %)	42.5	48.6	50.1	40.8	44.5
Гадаад өр (ДНБ-д эзлэх хувь)	220.6	240.6	219.1	219.4	244.8 <sup>е</sup>
<b>Ядуурал, нийгмийн үзүүлэлтүүд</b>	<b>2016<sup>б</sup></b>		<b>2020<sup>б</sup></b>		
Хүн ам (сая)	3.1		3.3	[2019]	
Хүн амын өсөлт (жилийн өсөлт, %-аар)	2.0		1.8	[2019]	
Эхийн эндэгдэл (100,000 амьд төрөлт тутамд)	49.2		30.7		
Нярайн эндэгдэл (1 хүртэл насны/1,000 амьд төрөлт тутамд)	16.9		11.5		
Төрөлтөөс тооцсон дундаж наслалт (жилээр)	69.6		70.4	[2019]	
Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалт (%)	98.3	[2010]	98.7		
Бага сургуульд хамрагдалт (%)	98.1		96.8	[2019]	
Хүүхдийн хоол тэжээлийн дутагдал (% , 5 хүртэлх насны хүүхэд)	7.3		9.4	[2018]	
Ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн ам (%)	29.6		28.4	[2018]	
Цэвэр усны хангамжтай хүн ам (%)	51.6	[2010]	78.8		
Ариун цэврийн байгууламж ашигладаг хүн ам (%)	23.2	[2010]	30.4		
<b>Байгаль орчны үзүүлэлтүүд<sup>б</sup></b>	<b>2015</b>		<b>2019</b>		
Нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт (тонн)	32,687	[2013]	34,483	[2014]	
Нэг хүнд ноогдох нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт (тонн)	11.2	[2013]	11.4	[2014]	
Ойн сан бүхий газар (сая га)	14.334		14.337		
Хотын хүн ам (нийт хүн амд эзлэх%)	67.99		68.52		
<b>АХБ-ны төсөл хөтөлбөр (идэвхтэй зээл ба АХС-ийн буцалтгүй тусламж)<sup>с</sup></b>				<b>2020.12.30-ны байдлаар</b>	
Нийт зээл ба АХС-ийн буцалтгүй тусламжийн тоо					
Засгийн газрын					45
Засгийн газрын бус					4
Нийт зээл ба АХС-ийн буцалтгүй тусламжийн дүн (сая ам.доллар) <sup>е</sup>					
Засгийн газрын					1,499.9
Засгийн газрын бус					62.1
Зарцуулалт (Засгийн газрын зээл)					
Нийт зарцуулсан дүн (сая ам.доллар, 2020)					334.8
БСЗ-ээс бусад зарцуулсан дүн (сая ам.доллар, 2020)					174.8
БСЗ-ээс бусад зарцуулсан хувь (%)					21.5

( ) = сөрөг; [ ] = мэдээлэл авах боломжтой сүүлчийн он, АХБ = Азийн Хөгжлийн Банк, АХС = Азийн Хөгжлийн Сан, ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн, ҮНО = үндэсний нийт орлого, M2 = нийт мөнгө, БСЗ = бодлогод суурилсан зээл.

<sup>а</sup> Монгол Улсын санхүүгийн жил 1-р сарын 1-ээс 12-р сарын 31-г дуустал хамарна. Бүх тоо мэдээлэл тухайн санхүүгийн жилд хамаарна.

- <sup>b</sup> Өөрөөр заагаагүй бол, тоо мэдээлэл 2016 ба 2020 онд хамаарна.
- <sup>c</sup> Өөрөөр заагаагүй бол, тоо мэдээлэл 2015 ба 2019 онд хамаарна.
- <sup>d</sup> АХС ба ЕХЭҮ-ээс гарсан төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг хамрах бөгөөд өөрөөр заагаагүй бол бодлогод суурилсан зээлийн дүн багтсан.
- <sup>e</sup> Батлагдах явцад хасагдсан болон цуцлагдсан зээлийн дүнг оруулаагүй болно.

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам. 2018. *Монгол Улсын байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018*. Улаанбаатар; Байгаль орчин, аялал жуулчлалын яам. 2018. *НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх суурь конвенцид хүргүүлэх Монгол Улсын Гурав дахь үндэсний тайлан*. Улаанбаатар; Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. 2015, 2020. *Монгол Улсын статистикийн эмхэтгэл–2014, 2019*. Улаанбаатар; Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. 2020. *Статистикийн мэдээллийн үйлчилгээ*. Улаанбаатар; Монголбанк. 2020. *Сар бүрийн статистикийн тайлан*. Улаанбаатар; Монголбанк. 2020. *Гадаад секторын статистик тойм–2015-2020*. Улаанбаатар.

## I. ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ГОЛ АГУУЛГА

1. **Хөгжлийн замд тулгарч буй гол сорилтууд.** Монгол Улс 30 жилийн өмнө АХБ-д гишүүнээр элсэн орсноосоо хойш гайхалтай ахиц дэвшил гаргаж, 2050 он гэхэд хүчирхэг дундаж давхарга бүхий орчин цагийн эрчтэй эдийн засагтай улс болон хөгжих томоохон зорилтыг тавин ажиллаж байна.<sup>1</sup> Энэхүү зорилтын биелэлтэд коронавируст өвчин (КОВИД-19) томоохон саад учруулж байгаа бөгөөд өнөөдөр Монгол Улсын хувьд зорилтот бүлгийн дархлаажуулалтыг гүйцээн, хямралыг даван туулж, эдийн засгийн өсөлт болон хүний хөгжилдөө эргэн анхаарал хандуулах нь нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудал болоод байна. Харин хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг бий болгож чадахуйц олон тулгууртай, гадны нөлөөнд тэсвэртэй эдийн засгийг хөгжүүлэх нь Монгол Улсын өмнө тулгарч буй урт хугацааны сорилт юм. Үүний тулд Монгол Улс ажлын байр олноор бий болгох салбаруудаа түлхүү хөгжүүлэх замаар эдийн засгийн бааз сууриа өргөжүүлэн, эмэгтэйчүүд, залуучууд болон хөгжлөөс орхигддог нийгмийн бусад бүлгүүдийг эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн хэмжээнд оролцоход нь саад болдог тэгш бус байдлыг арилгахын тулд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарыг бэхжүүлэх хэрэгтэй. Хотжилт эрчимжиж буй өнөөгийн нийгмийн хэрэгцээг хотын дэд бүтэц гүйцэхгүй байгаа бөгөөд дэд бүтцийн хөгжил ийнхүү сул байгаа нь Монгол Улсын худалдааны боломжуудыг хязгаарлаж байна. Түүнчлэн, бэлчээр, ус, агаар, ой мод зэрэг байгалийн баялаг нь даацаас хэтэрсэн хэрэглээ болон бохирдуулалтын улмаас доройтсоор байгаа бөгөөд улмаар уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл зэрэг асуудалтай зэрэгцэн иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлсөөр байна. Эдгээр чиглэлээр ахиц дэвшил гаргахын тулд засаглалыг сайжруулж, бодлогын залгамж чанар, макро эдийн засгийн тогтвортой байдлыг ханган, хөрөнгө оруулалт ба бизнесийн таатай орчинг төлөвшүүлэх шаардлагатай юм.

2. **Стратегийн зорилтууд ба тэргүүлэх чиглэлүүд.** 2021-2024 онд Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн хүрээнд АХБ Монгол Улсад КОВИД-19 цар тахлын хямралыг даван туулж, хүртээмжтэй бөгөөд тогтвортой хөгжлийн суурийг тавихад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор төрийн ба хувийн хэвшлийн салбарт хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ бодлогын шинэчлэл хийх, чадавхи бэхжүүлэх зэрэгт анхааран, мэдлэгийн дэмжлэгээр ханган ажиллана. Ингэхдээ АХБ дараах гурван стратегийн чиглэлийг баримтлана. Үүнд: (i) хүртээмжтэй нийгмийн хөгжил ба эдийн засгийн боломжуудыг хөхиүлэн дэмжих, (ii) өрсөлдөх чадвар ба эдийн засгийн төрөлжилтийг дэмжих уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх, (iii) ногоон бөгөөд уур амьсгалд зохицсон тогтвортой хөгжлийг цогцлоох зэрэг болно. АХБ нь жендэрийн тэгш байдал, цахим шилжилт, төр ба хувийн хэвшлийн түншлэлийг хамруулсан хувийн хэвшлийн оролцоо, институцийн чадавх ба засаглал, иргэний нийгмийн хамтын ажиллагаа гэсэн таван сэдэвчилсэн тэргүүлэх чиглэлийг мөн тодорхойлоод байна.

3. **АХБ-ны стратеги болон Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан байдал.** Энэхүү түншлэлийн стратеги нь эдийн засгийг идэвхжүүлэх, ажлын байрыг олноор бий болгох, хүртээмжтэй бөгөөд тогтвортой хөгжлийг цогцлоох<sup>2</sup> замаар КОВИД-19 цар тахлыг даван туулахад чиглэсэн Алсын хараа-2050 болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөр (ҮАХ)-тэй уялдсан. Түүнчлэн,

<sup>1</sup> Улсын Их Хурал. 2020. *Монгол Улсын Алсын хараа–2050*. Улаанбаатар.

<sup>2</sup> Улсын Их Хурал. 2020. *Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр, 2020-2024*. Улаанбаатар.

АХБ-ны 2030 он хүртэлх стратеги, 2017-2020 оны түншлэлийн стратегийн эцсийн үнэлгээ болон АХБ-ны ХБҮГ-аас гаргасан баталгаажилтийн<sup>3</sup> дүгнэлттэй бүрэн нийцсэн.

4. **Үнэ цэнэ бүтээж, төсөл хөтөлбөр сонгох аргачлал.** Монгол Улсын хамгийн том хөгжлийн түншийн хувьд АХБ нь өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн үйл ажиллагааныхаа бат бөх сууринд түшиглэн уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах хүчин чармайлтуудыг эрчимжүүлж, бизнесийн орчныг сайжруулж, КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээгээр дамжуулан эрүүл мэнд ба нийгмийн хамгааллын салбарт урт хугацааны, бодит шинэчлэлийг хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор инновацийг түүчээлнэ. АХБ нь КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг үргэлжүүлэх, ирээдүйд тохиож болзошгүй онцгой байдалд бэлэн байх зорилгоор тус улсад хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн төлөвлөлтөө уян хатан байлгана. Түүнчлэн, Монгол Улсад зориулагдсан санхүүжилтийн нийт дүнг бууруулахгүйгээр, төсөл хөтөлбөрийн тоогоо багасгаж арай цөөн тооны, томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд анхаарна. Ийм сонголт хийхдээ дараах тэргүүлэх чиглэлийг баримтална, үүнд: (i) КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээг эрчимжүүлэх; (ii) өөрийн давуу тал ба хөгжлийн түншүүдийн уялдаа холбоонд түшиглэн салбар бүрт хэрэгжүүлэх үйл ажиллагааны голлох чиглэлүүдийг тодорхойлох; (iii) газар зүйн зорилтот байршилд төвлөрөх цогц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх (эхний ээлжинд Монгол Улсын баруун бүсэд төвлөрнө); (iv) төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх бэлэн байдалд онцгой анхаарал хандуулах; (v) хувийн хэвшлийг төсөл хөтөлбөрүүдэд түлхүү оролцуулах. АХБ-ны үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга барилын цөм нь төрийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааг мэдлэг шилжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуудахад оршино.

## II. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

5. **Монгол Улсын хөгжлийн ахиц дэвшилд огцом өсөлт-уналтын мөчлөг сөргөөр нөлөөлж байна.** Монгол Улс нь дундаас доош орлоготой орны ангилал руу амжилттай шилжсэн, далайд гарцгүй, байгалийн баялаг ихтэй улс юм. 2000 оноос хойш зэрэгцүүлэх үнээр тооцсон нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) гурав дахин нэмэгдсэн ч ахиц дэвшлийн замнал савлагаатай, эдийн засгийн өсөлт болон ядуурлын үзүүлэлт маш их хэлбэлзэлтэй байсаар ирсэн нь Монгол Улсын эдийн засаг эрдэс баялгаас хамааралтай (нийт экспортын 92.8 хувь нь уул уурхайн гаралтай) бөгөөд түүхий эдийн үнийн хэлбэлзэлд өртөмтгий байгаагийн илрэл юм.<sup>4</sup> Уул уурхай нь хязгаарлагдмал тооны буюу нийт ажлын байрны ердөө 4.6 хувийг бүрдүүлж, эдийн засагт хэт хэлбэлзэлтэй нөлөө үзүүлдэг учир үе үеийн засгийн газрын тэргүүний зорилт нь эдийн засгийг төрөлжүүлэх байсан. Монгол Улс хөдөө аж ахуй, аялал жуулчлал, үйлчилгээ ба сэргээгдэх эрчим хүчний салбарын экспортын нөөц бололцоог ашиглаж, богино хугацаандаа ажлын байр олноор бий болгон, урт хугацаандаа эдийн засаг төрөлжих суурийг тавих боломжтой.<sup>5</sup> Ингэхдээ, цочрол хямралыг цөөлж, өрийн тогтвортой байдлыг хангахын тулд мөчлөг сөрсөн макро эдийн засгийн бодлого зайлшгүй шаардагдана. Монгол Улсын төсвийн хууль тогтоомж энэ талдаа сайн туршлагад тооцогддог ч 2017 он хүртэл хэрэгжилт нь хангалтгүй байв. Цаашид дотоодын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг илүү сайн дайчлах, төсвийн орлогын савлалтыг бууруулах, татварын шинэчлэлийг хийх шаардлагатай байна. Хөдөлмөр эрхлэлтийг тэлэх нэг арга бол уул уурхайн салбарыг бүхэлд нь шинэчилж, ханган нийлүүлэлтийн сүлжээнд нь нэмүү үнэ

<sup>3</sup> ХБҮГ. 2021. Монгол Улс. *Улс оронтой хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн эцсийн үнэлгээний баталгаажилт, 2017-2020*. Манила.

<sup>4</sup> Бусад эмзэг асуудлыг дурдвал Монгол Улс байгалийн гамшигт өртөмтгий бөгөөд экспортын худалдаа нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас хамааралтай зэрэг болно.

<sup>5</sup> Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалтын дунджаар 73.1 хувь нь уул уурхайн салбарт орж байгаа тул ойрын ирээдүйд уул уурхайн экспорт давамгайлсан байдал хадгалагдана.

цэнэ бүтээн, ажлын байр бий болгохыг хөхиүлэн дэмжихийн сацуу эрдэс баялгийн орлогыг зөв зохистойгоор удирдах юм.

**6. КОВИД-19 цар тахлын улмаас эдийн засаг огцом агшиж, макро эдийн засгийн шинэтгэлийн явц удаашрав.** КОВИД-19 цар тахал тохиохын өмнөх 2017-2019 онуудад Монгол Улсын эдийн засаг тууштай өсөж байв. Энэ хугацаанд Засгийн газраас төсвийн гүйцэтгэлийг ашигтай гаргах, өрийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, гадаад валютын нөөцөө нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авсан. 2020 онд КОВИД-19 цар тахлын хямралаас үүдэн эдийн засаг 5.3 хувиар агшсаны улмаас нийт өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 14.1 хувиар өссөн. 2017-2019 оны хооронд энэ харьцааг 30 хувиар бууруулаад байсан амжилт буцан ухарч, 2021-2024 онд 4.8 тэрбум ам.долларын Засгийн газрын гадаад өр эргэн төлөгдөх тул цаашид маш ухаалаг удирдлагыг шаардах болно. Төлбөрийн тэнцлийн дарамтууд байгаа ч 2020 оны эцсээр гадаад валютын нөөц 7.4 сарын импортыг хангахуйц хэмжээнд өссөн. Гэхдээ Монголбанк валютын нөөцөө нэмэгдүүлэхдээ валютын своп хэлэлцээр ашигласаар байгаа тул илүү тогтвортой аргачлалд шилжих хэрэгтэй байна. КОВИД-19 цар тахлын хямрал санхүүгийн салбар дахь урт хугацааны эрсдэлүүдийг даамжруулсан ба банкны салбарт чанаргүй зээл, өөрийн хөрөнгийн хангалтгүй нөөцийн асуудлууд хурцдах төлөвтэй байна.

**7. КОВИД-19 цар тахлын эсрэг шийдвэрлэх арга хэмжээг авч, дархлаажуулалт хурдтай явагдаж байна.** 2020 оны 1-р сараас хойш Засгийн газраас хил хаах, хөл хорио тогтоох зэрэг өргөн хүрээний арга хэмжээ авсаар ирсэн. Монгол Улсад 2020 оны 11-р сар хүртэл дотоодын халдвар бүртгэгдээгүй байсан ч үүнээс хойш халдварын тохиолдол байнга өссөөр 2021 оны 7-р сарын 26-ны өдрийн байдлаар 157 гаруй мянган тохиолдол бүртгэгдээд байна. Монгол Улс вакцинжуулалтыг 2021 оны 2-р сард эхлүүлж, 2021 оны 7-р сарын 26-ны өдрийн байдлаар зорилтот хүн амын 81.9 хувийг дархлаажуулаад байна. Засгийн газраас хоёр төрлийн багц хөтөлбөрийг эхлүүлсэн. 2020 оны 1-р улиралд зарласан 1.8 тэрбум ам.долларын үнийн дүн бүхий Мөчлөг сөрсөн хөгжлийн төлөвлөгөө нь эрүүл мэндийн салбар, татварын хөнгөлөлт болон нийгмийн халамжийн төсвийн санхүүжилтийг нэмсэн. 2021 оны 2-р сард зарласан 3.5 тэрбум ам.долларын, 3 жилийн хугацаанд хэрэгжих “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө” нь эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн. Түүнчлэн, Монголбанкнаас банкны дарамтыг хөнгөлөх, жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ), аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилготой хэд хэдэн бодлогын арга хэмжээг аваад байна.<sup>6</sup>

**8. Монгол Улс дахь ужгирсан тэгш бус байдал КОВИД-19 цар тахлын улмаас даамжраад байна.** Монгол Улсын ядуурлын түвшин 2010 онд 38.8 хувь байсан бол 2014 онд 21.6 хувь болж тууштай буурсан юм. 2016 онд ядуурлын түвшин 29.6 хувь хүртэл дахин өссөн бол 2018 онд 28.4 хувь болж буурчээ. Гэвч хүн амын 27.3 хувийн амьжиргаа нь ядуурлын шугамыг давах төдий байна.<sup>7</sup> КОВИД-19 цар тахалтай холбоотой эдийн засгийн агшилтын улмаас бүх томоохон салбарт ажлын байр цөөрч, ажилгүйдэл ба бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт 2020 онд 1.4 хувиар нэмэгдэв.<sup>8</sup> Монгол Улс дахь тэгш бус байдлын бусад асуудлыг дурдвал, хүүхэд, ид насныхан (30-39 насны бүлэг), хөгжлийн

<sup>6</sup> Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ: бодлогын хүүг 5 хувиар бууруулж 6 хувь болгосон; банкуудын дотоодын валютын нөөц болон хөрвөх чадварын босгод тавих шаардлагыг зөөллөсөн; КОВИД-19 цар тахлын үед ЖДҮ, аж ахуйн нэгжүүд болон уул уурхайн бус экспортыг дэмжих зорилгоор төлбөрийн чадварыг нь дэмжих арга хэмжээ хэрэгжүүлсэн.

<sup>7</sup> Монгол Улсын хүн амын 28.4% нь үндэсний ядуурлын шугамаас доогуур буюу нэг хүнд ногдох сарын орлого нь 166,580 төгрөгөөс бага амьжиргаатай байна. Түүнчлэн, хүн амын 27.3% нь ядуурлын шугамын 150% буюу нэг хүнд ногдох орлого нь 249,870 төгрөг хүртэлх амьжиргаатай байна.

<sup>8</sup> Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн үйлчилгээнд тулгуурласан АХБ-ны тооцоо. 2021.

бэрхшээлтэй иргэд болон хөдөөгийн оршин суугчид ядууралд өртөх эрсдэл нь илүү өндөр байна. Гэхдээ, хотжилт эрчимжиж байгаа тул нийт тоогоор нь авч үзвэл хот суурин газарт илүү олон ядуу иргэн амьдарч байна. Дээр дурдсан бүлгүүд КОВИД-19 цар тахалд түлхүү өртөн,<sup>9</sup> залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ид насныхны хөдөлмөр эрхлэлт хумигдаж, хөдөөгийн оршин суугчид цахим сүлжээнд холбогдох боломж хязгаарлагдмал тул боловсрол гэх мэт үйлчилгээнд хамрагдахгүй орхигдож байна. Эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр буюу асаргааны ажлын ачаалал ихсэж, эмэгтэйчүүд давамгайлдаг эрүүл мэндийн салбар болон эмэгтэйчүүдийн голлон эрхэлдэг бичил ба өрхийн бизнес КОВИД-19 хямралд түлхүү өртсөн зэргээс шалтгаалж жендэрт суурилсан тэгш бус байдал даамжраад байна.

**9. Бодлого боловсруулах үйл ажиллагаанд институцийн чадавх сэргөөр нөлөөлж байна.** Улс төрийн тогтвортой бус байдал нь урт хугацааны төлөвлөлт болон бодлогын залгамж чанарт саад тотгор учруулдаг учир шийдвэрлэх шаардлагатай асуудал болсоор ирсэн. Монгол Улсад төрийн санхүүгийн удирдлагатай холбоотой цөөнгүй сорилтууд тулгарч байна. Үүнд байгалийн баялгаас олсон орлогын зохисгүй менежмент, үр ашиггүй зардлын менежмент болоод татварын орчинд шаардагдаж буй шинэтгэлийг нэрлэж болно. Үе үеийн засгийн газрууд авилгатай тэмцэх бодлогыг тэргүүлэх чиглэлд тавьсаар ирсэн ч олон нийтийн дунд авилгын төсөөлөл өндөр хэвээр байна. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэх мэт хараат бус байгууллага болон зохицуулалтын, мэргэжлийн агентлагууд чиг үүргээ бүрэн гүйцэтгэхэд чадавх бөгөөд нөөц бололцоо нь дутмаг байна. Засаглалын хувьд бэхжүүлэх шаардлагатай чиглэлүүдэд хуулийн засаглал, ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, хэвлэлийн болон иргэний нийгмийн эрх чөлөө, өндөр чадамжтай, хараат бус төрийн албыг төлөвшүүлэх шаардлага хэрэгцээ зэрэг багтаж байна.

**10. Нийгмийн хамгаалал чухал бөгөөд үр өгөөжийг нь дээшлүүлэх шаардлагатай байна.** Монгол Улсад урьд өмнө тохиож байсан хямралын туршлагаас харахад, хямралтай дасан зохицох сөрөг стратеги авч хэрэгжүүлэх нь айл өрхүүдийг урт хугацаандаа сэргөөр нөлөөлөх сонголт хийхэд хүргэдэг. Нийгмийн хамгааллын тогтолцоо харьцангуй төлөвшсөн ч олон хөтөлбөрүүдийг хооронд нь нэгтгэх, үр өгөөж хүртэх ёстой хүмүүсийг илүү сайн тодорхойлох зэргээр ядуурлыг дорвитойгоор бууруулж, тэсвэртэй байдлыг сайжруулах боломжтой. Тогтолцоогоо ийнхүү сайжруулахын хажуугаар нотолгоонд суурилсан бодлого боловсруулалтад түлхүү анхаарч, институцийн чадавхыг бэхжүүлэх нь зүйтэй. Түүнчлэн, төрийн тэтгэврийн тогтолцооны төсвийн санхүүжилт урт хугацаандаа тогтвортой бус, хувийн тэтгэврийн тогтолцоо хараахан бүрэлдээгүй, өндөр настны асаргааны үйлчилгээ дөнгөж хөгжиж эхэлж байгаагаас улбаалж хүн амын насжилттай холбоотой сөрөг үр дагавар эрэгтэйчүүдээс илүү өндөр дундаж наслалттай байгаа эмэгтэйчүүдэд хүндээр тусах талтай байна.

**11. Монгол Улсын эрүүл мэндийн салбар КОВИД-19 цар тахлын хүндхэн сорилттой нүүр тулж байна.** Эрүүл мэндийн салбарын өмнө өнөөдөр тулгарч байгаа тэргүүний зорилт бол хүн амаа КОВИД-19 өвчний эсрэг дархлаажуулж дуусгахын зэрэгцээ ирээдүйд тулгарч болзошгүй эрсдэлийг удирдах бэлэн байдлыг бэхжүүлэх явдал болоод байна. КОВИД-19 цар тахлын эрүүл мэндийн тогтолцоонд үзүүлж буй дарамтын улмаас дундаж наслалт, эхийн болон 0-5 насны хүүхдийн эндэгдэл зэрэг үзүүлэлтээр тууштай урагшилж ирсэн Монгол Улсын ахиц дэвшил хойш татагдах аюул нүүрлээд байна. Эрүүл

---

<sup>9</sup> АХБ. 2021. *Монгол Улсын бичил, жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тогтвортойгоор сэргээх арга ажиллагааны хувилбарууд*. Манила ба НҮБХХ. 2021. *КОВИД-19 цар тахал Монгол эмэгтэйчүүд, охидод үзүүлж буй нөлөөлөл*. Нью Йорк.

мэндийн салбар шийдвэр гаргагчдын анхаарлын төвд байгаа нь цар тахлын дараах салбарын үйл ажиллагааг тогтвортойгоор бэхжүүлэхийц шинэтгэлийн ажлыг эрчимжүүлэх боломжийг бүрдүүлж байна. Ингэхдээ анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээний төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлж, эмнэлгүүд төсөв санхүүгийн хувьд илүү бие даан ажиллаж, эм бэлдмэлийн нэгдсэн худалдан авалтыг өргөжүүлэхийн зэрэгцээ эм бэлдмэлийн зохицуулалтыг хариуцах төрийн байгууллага бий болж байгааг ашиглан тусламж үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх хэрэгтэй.

**12. Боловсролын чанар хангалтгүй байгаа нь тулгамдсан асуудал хэвээр байна.** Боловсролын чанарын үзүүлэлтүүд сайжрахгүй байгаа тул чанарыг дээшлүүлэх асуудал эн тэргүүнд тавигдах бодлогын зорилт болж байна. Техник, мэргэжлийн боловсрол ба сургалтын тогтолцоо төлөвшөөгүйгээс төгсөгчдийн ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцэхгүй байгаа тул залуучуудын ажилгүйдэл өндөр (24.2 хувь) байна. Үндсэндээ бүх салбарын хөдөлмөрийн бүтээмж бага байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнхи нь ажилладаг хөдөө аж ахуй ба үйлчилгээний салбар хамгийн их хоцролттой байна. Монгол Улсын эдийн засгийг амжилттай төрөлжүүлэхийн тулд хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. КОВИД-19 цар тахлын улмаас хүүхдүүд нэг жил гаруй хугацаанд танхимаар хичээллээгүй тул нэн ялангуяа бага орлоготой айл өрхийн хүүхдүүд хичээлийн хоцрогдол ихтэй байна.

**13. КОВИД-19 цар тахлын улмаас жендэрийн тэгш байдал доройтож байна.** 2006 оноос хойш хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо тасралтгүй буурч байгаа нь сэтгэл түгшээсэн асуудал юм. КОВИД-19 цар тахлын үед цалин хөлсгүй асаргаа арчилгааны ачаалал эмэгтэйчүүдэд голлон ногдож буй нь нөхцөл байдлыг хүндрүүлж байна. Үүний улмаас эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо буурч, улмаар Монгол Улс жил бүр ДНБ-ийхээ 0.5 хувийн өсөлтийг алдаж байна.<sup>10</sup> Түүнчлэн, улс төрийн өндөр албан тушаал болон уул уурхай зэрэг тэргүүлэх салбар дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй байна.<sup>11</sup> Монгол Улс жендэрийн тэгш байдлыг хууль тогтоомж, бодлогын орчиндоо бүрэн тусгасан ч хэрэгжилт учир дутагдалтай байна. Жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн асуудал ноцтой тавигдаж байгаа бөгөөд КОВИД-19 цар тахал нөхцөл байдлыг улам хүндрүүлжээ.

**14. Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжиж, санхүүгийн салбарыг төлөвшүүлэхэд анхаарах шаардлагатай хэвээр байна.** Монгол Улсын эдийн засаг болон хөдөлмөр эрхлэлтийг хувийн хэвшлийн салбар нь голлон бүрдүүлдэг бөгөөд тус салбарт ЖДҮ давамгайлдаг. Бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг дурдвал, макро эдийн засгийн тогтворгүй байдал, бүрэн төлөвшөөгүй эрх зүйн орчин, гэрээний харилцааны сул зохицуулалт, авилга ба дүрэм журмын нийцлийн өндөр өртөг, ур чадвартай ажиллах хүчний хомсдол зэрэг байна. Бичил бизнесүүд ба ЖДҮ хүү багатай зээл авахад хамгийн их саад тотгортой тулж, КОВИД-19 цар тахалтай холбоотой эдийн засгийн агшилт тэдэнд хамгийн хүндээр туссан. Санхүүгийн салбарт давамгайллагч банкуудын хувьд зохицуулалтын орчин хэт зөөлөн, компанийн засаглал сул, чанаргүй зээлийн хувь хэмжээ өндөр бөгөөд буурах хандлагагүй, ашгийн түвшин төдийлөн өндөр бус, зохистой хөрөнгийн шаардлагыг тэр бүр хангаж чаддаггүй зэрэг асуудлууд бий. Монгол Улс 2019 ба 2020 онд Санхүүгийн арга хэмжээ авах ажлын хэсгийн саарал жагсаалтад нэг жилийн турш бүртгэлтэй байсан нь санхүүгийн салбарт бодлогын манлайлал болон тууштай арга хэмжээ үгүйлэгдэж

<sup>10</sup> АХБ. 2020. *Хөдөлмөрийн зах зээлд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангаснаар Монгол Улсын урт хугацааны эдийн засгийн хөгжилд түлхэц өгөх нь*. Манила.

<sup>11</sup> Уул уурхайд эмэгтэйчүүдийн оролцоо бага тул эдийн засгийг төрөлжүүлснээр эмэгтэйчүүдийн төлөөлөл өндөртэй салбаруудын хөгжилд түлхэж болж, жендэрийн тэгш бус байдлыг бууруулах боломж бүрдэнэ.

байгаагийн анхааруулга болсон юм. Дэд бүтцийн бүтээн байгуулалт дахь хувийн хэвшлийн оролцоо хөгжлийн эрт үеийн шатандаа байна. ТХХТ-ийг хэрэгжүүлэх институцийн тогтолцоо ба Засгийн газрын хэрэгжүүлэлтийн чадавх хөгжөөгүй хэвээр байна.

15. **Хотын дэд бүтэц хөгжөөгүй нь тулгамдсан асуудал хэвээр байна.** Хот суурин газрын захиргаануудад санхүүгийн нөөц бололцоо хомс, засаглалын орчин дутмаг байна. Дэд бүтцийн хөгжил дорой тул эдийн засгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, хотын дахин төлөвлөлтийн ажилд саад болсоор байгаа юм. Замын хөдөлгөөний түгжрэл хурцаар тавигдаж буй нийслэл Улаанбаатар хотын хувьд хүртээмжтэй, үр ашигтай, аюулгүй нийтийн тээврийн тогтолцоо нэн түрүүнд үгүйлэгдэж байна. Хотын оршин суугчдын гуравны нэг нь дэд бүтэц, ариун цэврийн байгууламж, хотын нийтийн үйлчилгээгээр хангагдаагүй, бохирдол ихтэй, амьдрах орчин муутай гэр хороололд амьдарч байна. Гэр хорооллыг дахин төлөвлөлтөд хамруулж, Улаанбаатарын төвлөрлийг сааруулж чадвал замын түгжрэлийг бууруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх болно. Орон нутаг дахь хот суурин газрууд (аймгийн төвүүд ба бусад хот) мөн ижил хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаа бөгөөд үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа нь бизнесийн хөгжих боломжийг хумьж, тухайн орон нутгийн эдийн засгийн хөгжлийг хязгаарлаж, ажлын байр бий болгох боломжийг хазаарлаж байна. Үүний улмаас хөдөөгийн оршин суугчид эдийн засгийн боломжуудыг эрэлхийлэн Улаанбаатар хот руу шилжин суурьших хөдөлгөөн зогсолтгүй үргэлжилж, эцэстээ нэг талдаа хөдөө орон нутаг хөгжихгүй, нөгөө талдаа Улаанбаатар хотын дэд бүтцийн ачаалал хэтэрч байна.

16. **Хөдөө орон нутагт хөрөнгө оруулалт татах шаардлагатай.** Хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт дутмаг, дэд бүтэц хөгжөөгүй, нийтийн үйлчилгээ хүртээмжгүй зэрэг хүндрэл бэрхшээл тулгардаг. Малын тоо толгой өндөр байгаа нь бэлчээрийг доройтуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг алдагдуулж байна. Түүнчлэн, өвлийн улиралд малын зүй бус хорогдол их, малын халдварт өвчин түгээмэл, олон улсын худалдааны стандартад нийцдэггүй зэрэг тулгамдсан асуудлуудыг дурдаж болно. Газар тариалангийн хувьд усалгааны дэд бүтэц хуучирсан, хөрсний үржил шимт чанар доройтсон, чадварлаг ажиллах хүчин болон бусад нөөц хомс зэрэг асуудалтай байна. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг сайжруулж, нэмүү үнэ цэнийг бүтээхийн тулд байгалийн баялгийн удирдлагыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ авч хэрэгжүүлэх, өрсөлдөх чадвартай үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ илүү сайн бүтээмж, стандарт бүхий төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэсэн үнэ цэнийн сүлжээг бэхжүүлэх шаардлагатай байна.

17. **Гадаад худалдааг нэмэгдүүлэх боломжийг сул дорой дэд бүтэц боомилж байна.** Монгол Улсын төрийн институцийн тогтолцоо нэгдмэл бус, төр-хувийн хэвшлийн түншлэл төлөвшөөгүй, тодорхой хариуцагч байгууллага байхгүйн улмаас гадаадын хөрөнгө оруулалтын бодлого уялдаа холбоогүй байна. Замын засвар үйлчилгээ хангалтгүй, төмөр замын сүлжээ бүрдээгүй, ложистик үр дүнтэй хөгжөөгүй байгаа нь тээврийн өртгийг нэмэгдүүлж худалдааны өрсөлдөх чадварыг сулруулж байна. Хил дамнасан худалдааг хөнгөвчлөхийн сацуу хил дамнан нэвтэрч болзошгүй аливаа эрсдэлд бэлтгэлтэй байх чадавхыг бэхжүүлэх шаардлагатай. Хүчирхэг манлайллын зэрэгцээ цахим технологийг оновчтой ашиглаж, дэд бүтцэд зорилтот хөрөнгө оруулалт хийж, Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагаа буюу КАРЕК гэх зэрэг бүсийн санаачлагад илүү идэвхтэйгээр оролцох нь Монгол Улсын гадаад худалдааг гүнзгийрүүлэн өргөжүүлэхэд тус болно.

18. **Сэргээгдэх эрчим хүчний нөөц бололцоогоо хөгжүүлэн ашиглавал эрчим хүчний салбар дахь хэт ачааллыг багасгана.** Цахилгаан ба дулааны эрчим хүчний хэрэгцээ өдгөө ашиглагдаж буй хуучин дулааны цахилгаан станцуудын хүчин чадлаас



ихээхэн давж байна.<sup>12</sup> Эрчим хүчний салбарын ялгаруулж буй бохирдол үлэмж бөгөөд хүлэмжийн хийн ялгаруулалт, агаарын бохирдлын томоохон эх үүсвэр болдог.<sup>13</sup> Өнөөгийн тогтолцооны ашиглалтын зардал асар өндөр тул Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний нэн их нөөц бололцоогоо бүрэн ашиглах тогтолцоо руу шилжих цогц төлөвлөгөө шаардлагатай байна. Ингэхдээ, суурин газруудын дулааны төвлөрсөн сүлжээнд шинэчлэл хийж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглан, цэнэг хадгалагч байгууламжуудыг олноор байгуулах болон эрчим хүчний ухаалаг системийн аргачлалыг нэвтрүүлэх замаар цахилгаан дамжуулах сүлжээний даац ба уян хатан чанарыг сайжруулахын сацуу дамжуулалт, түгээлт ба хэрэглээний шат бүрд эрчим хүчний ашигт ажиллагааг дээшлүүлэх шаардлагатай. Түүнчлэн, Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний салбарт тавьсан зорилтуудыг биелүүлэхэд хувийн хэвшлийн эрчим хүчний бие даасан үйлдвэрлэгчдийг татан оролцуулахын тулд төрөөс хэрэгжүүлэх чадавхаа бэхжүүлж, институцийн тогтолцоогоо төлөвшүүлэх шаардлагатай байна.

**19. Байгалийн гамшиг ба уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх нь зүйтэй.** Байгалийн гамшигт үзэгдэл ба уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн даацаас хэтэрсэн ашиглалт ба хөрсний доройтол зэрэг нь бага орлоготой иргэдэд хамгийн хүндээр тусаж, үүнд малчид, хөдөөгийн оршин суугчид нэн ихээр өртөж байна. Гэр хороолол өргөжин тэлэхийн хирээр үер, газар хөдлөлт, гал түймрийн эрсдэл нэмэгдэнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг байгаль хамгаалалтай холбосноор хөдөө орон нутгийн гамшигийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх бөгөөд бэлэн байдлыг хангахад чиглэсэн, оршин суугчдад түшиглэсэн санаачлагуудаас гадна нийгмийн хамгаалал, даатгалд сайн хамруулж, шаардлагатай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна. Үндэсний гамшгийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөнүүдийг сайжруулахын тулд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан судалгаа, үнэлгээнд түшиглэн төв ба орон нутгийн захиргаа хоорондын болон агентлагууд хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг эрчимжүүлэх хэрэгтэй.

**20. Ногоон хөгжлийг цогцлоохын тулд байгалийн нөөцийг хамгаалах хэрэгтэй.** Монгол Улс нь өргөн уудам тал хээр, нэг хүнд ногдох усны нөөцийн хүртээмж, ой мод, намгархаг газар, газрын доорхи эрдэс зэрэг байгалийн баялаг нөөцтэй ч байгалийн нөхөн сэргээлт нь ашиглалтын хурдыг гүйцэхгүй байгаагаас байгалийн нөөцийн хэмжээ ба чанар муудаж байгаа. Тухайлбал, тус улсын нийт бэлчээрийн 70 хувь доройтсон нь уламжлалт мал аж ахуй ба уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх чадварт аюул учруулж байна. Цэнгэг усны нөөц ихтэй ч бохирдол нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай үер, ган, зудын улмаас хүртээмж ба чанар нь доройтсоор. Хот суурин газар, хөдөө аж ахуй ба уул уурхайн үнэ цэнийн сүлжээний ус хангамжийн дэд бүтэц хөгжөөгүй, ашиглалт даацаас хэтэрсэн, нөөцийн зохистой удирдлага хийгддэггүйн улмаас эрсдэл тулгарч байна. Байгалийн нөөц тус улсын эдийн засагт асар их ач холбогдолтойг бүрэн ухаарахгүй, байгалийн нөөцөд оруулах хөрөнгө оруулалтыг тэргүүнд тавихад чиглэсэн эдийн засгийн тооцоо судалгаа хийгдэхгүй байна.

<sup>12</sup> Нүүрс ашигладаг дулааны цахилгаан станцууд төвийн эрчим хүчний систем дахь нийт үйлдвэрлэлийн 93 хувийг бүрдүүлдэг нь дотоодын хэрэгцээний 80 хувийг хангаж байна.

<sup>13</sup> Монгол Улс Парисын хэлэлцээрээр хүлээсэн зорилтот хувь нэмрээ шинэчлэхдээ 2030 он гэхэд үндэсний хэмжээнд ялгаруулдаг хүлэмжийн хийн хэмжээг 22.7 хувиар бууруулах амлалт өгсөн. Ялгаруулалтын голлох эх үүсвэрүүд нь эрчим хүч (50.1%) ба хөдөө аж ахуй (48.5%) бөгөөд эрчим хүчний салбар дотроо нүүрс ашиглалт, хөдөө аж ахуй салбар дотроо мал аж ахуй хамгийн том эх үүсвэр нь болж байна.

### III. ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

#### A. Өмнөх стратегиас авсан сургамжууд

21. **2021-2024 оны түншлэлийн стратегийг боловсруулахад 2017-2020 оны түншлэлийн стратегийн эцсийн үнэлгээ ба ХБҮГ-ын баталгаажуулсан тайланг чухалчлан авч үзсэн.** Эцсийн үнэлгээний тайланд (i) төсөл хэрэгжүүлэх бэлэн байдлыг сайжруулах, төсөл хөтөлбөрийн тоог бууруулах замаар үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах; (ii) төслийн үр дүнг тогтвортой байлгах зорилгоор төр, хувийн хэвшил, иргэний нийгэм болон хөгжлийн түншүүдтэй үр өгөөжтэй хамтран ажиллах; (iii) эдийн засгийн цочролын үед АХБ-наас цаг алдалгүй шуурхай хариу арга хэмжээ авах чадварыг бэхжүүлж, төсөл хөтөлбөрийн төлөвлөлтийг уян хатан байлгах; (iv) хувийн хэвшлийн оролцоог хөхиүлэн дэмжиж, бий болсон ахиц дэвшлийг гүнзгийрүүлэх; (v) хөгжлийн сорилтуудыг шийдвэрлэхийн тулд салбар дамнасан, олон хэмжээст аргачлалыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд чиглэсэн өргөн стратеги баримтлах; (vi) мэдлэг солилцох төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх замаар АХБ-ны урьд өмнөх үйл ажиллагаанаас олж авсан сургамжуудыг өргөнөөр түгээн дэлгэрүүлэх шаардлагатай байгааг онцолсон.

22. **ХБҮГ-аас гаргасан үнэлгээгээр 2017-2020 оны түншлэлийн стратегийг амжилттай хэрэгжсэн гэж дүгнэсэн бөгөөд КОВИД-19 вакцины тусламж болон эдийн засгийг төрөлжүүлэх талаар чухал зөвлөмжүүдийг өгсөн.** Баталгаажуулсан үнэлгээгээр АХБ үйл ажиллагаандаа дараах чиглэлүүдэд анхаарах шаардлагатайг зааж өгсөн: (i) үндэсний дархлаажуулалтын хөтөлбөрийг дэмжиж КОВИД-19 цар тахалтай холбоотой эрсдэлүүдийг хянах; (ii) хувийн хэвшлийг хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэхэд анхаарах; (iii) нийгмийн халамжийн тандалт хяналтын цахим мэдээллийн системийг ашиглалтад оруулахад үзүүлж буй дэмжлэгээ түргэтгэх; (iv) түншлэлийн стратегит тавьсан зорилтуудыг хангахад суурин төлөөлөгчийн газарт хангалттай нөөц бололцоо бий эсэхийг анхаарах; (v) дэд бүтцийн засвар, арчилгаанд илүү их ач холбогдол өгөх; мөн (vi) АХБ-наас Монгол Улсад байгаль орчны чиглэлээр олгож буй дэмжлэг тусалцаа нь урьд өмнөх ахиц дэвшлийг бататгахын сацуу шинээр үүсэж буй нөлөөллүүд нь өмнөх үр дүнг сааруулахгүй байхад анхааран ажиллах.

#### B. Үндэсний хөгжлийн стратеги

23. **Засгийн газраас гаргасан төлөвлөгөөнүүд КОВИД-19 цар тахлыг даван туулах, хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг цогцлоход төвлөрсөн.** Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр (тайлбар 2-г үзнэ үү) нь КОВИД-19 цар тахлын хор уршгийг арилгаж, хүн ба нийгмийн хөгжлийг дэмжин байгаль орчны менежментийг сайжруулахад чиглэсэн. ЗГҮАХ-т хувийн хэвшлийн хөгжил, жендэрийн тэгш байдлыг чухалчилсан бөгөөд дэд бүтцийг хөгжүүлэх томоохон төлөвлөгөөг тусгасан. 2021 оны 2-р сард зарласан “Эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгийг идэвхжүүлэх цогц төлөвлөгөө”-нд өмнө дурдсан зорилгуудын сацуу эдийн засгийг сэргээх, ажлын байр бий болгохыг онцлон тусгасан. Монгол Улсын Алсын хараа-2050 (тайлбар 1-г үзнэ үү) баримт бичигт эдийн засгийн тогтвортой өсөлт, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр ба аялал жуулчлалын хөгжил, байгаль орчны тогтвортой байдал, үүнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон хор уршгийг бууруулах зэрэг зорилт тусгасан байна. Тус төлөвлөгөөнүүд Монгол Улсын ТХЗ-уудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бөгөөд дундаж давхаргыг дэмжих, эдийн засгийн боломжуудыг бүх нийтэд хүртээмжтэй болгохыг чухалчилсан.

## **В. Хөгжлийн түншүүдийн гүйцэтгэх үүрэг**

24. **Хөгжлийн санхүүжилт зайлшгүй шаардлагатай хэвээр байна. 2011 оноос хойш** Монгол Улс жилд ойролцоогоор 500 сая ам.долларын зээлийн санхүүжилт авч байсан нь ДНБ-ийн 5 хувь, төсвийн нийт зарлагын 15 хувьтай тэнцэж байсан.<sup>14</sup> Хөгжлийн хамгийн том таван түншийн санхүүжилт нийт тусламж дэмжлэгийн 92 хувийг бүрдүүлдэг бөгөөд тэдгээр нь тээвэр, хотын дэд бүтэц ба нийгмийн хамгааллын салбарт голлон зарцуулагдаж байна.<sup>15</sup> Хөгжлийн түнш байгууллагууд хоорондоо болон Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулах үүднээс тогтмол уулзаж тодорхой сэдэв, салбар болон газар зүйн байршилтай холбоотой асуудлууд, хамтарсан санхүүжилт, бүтэцжүүлсэн хөтөлбөр буюу Олон улсын валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр гэх мэт асуудлаар хэлэлцдэг бөгөөд хамтарсан зөвлөгөөн, томилолт, цугларалт зохион байгуулдаг. Хөгжлийн түнш байгууллагууд иргэний нийгмийн байгууллага (ИНБ), хэвлэл мэдээлэл болон хувийн хэвшил зэрэг бусад оролцогч талуудтай зөвшилцөн ажилласаар ирсэн.

25. **Түншлэлийн стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд үр дүнтэй түншлэл, уялдаа холбоо ба хамтарсан санхүүжилт амин чухал.** АХБ нь томоохон хөгжлийн түнш байгууллагын байр сууриа цаашид ч хадгалан, тэргүүлэх салбарууд дахь хөгжлийн түншүүдийн уялдаа холбоо ба хамтын ажиллагааг сайжруулах тал дээр идэвхтэй ажиллах болно. Инновацийг дэмжих, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтөд хариу арга хэмжээ авах зорилгоор АХБ нь нэн ялангуяа хөнгөлөлттэй нөхцөл бүхий хамтарсан санхүүжилтийн хэлэлцээг амжилттай хийдэг давуу талаа дайчлах болно. Түүнчлэн Засгийн газрын томоохон зорилго тавьсан дэд бүтцийн хөгжлийн төлөвлөгөөнүүдэд шаардагдах чанартай санхүүжилтийг бүрдүүлэхийн тулд түнш байгууллагуудтай хөгжүүлсэн хамтын ажиллагаагаа ашиглан татан оролцуулна. Үүний тулд олон талт хөгжлийн банк болон байгууллагуудтай харилцаа холбоогоо гүнзгийрүүлэх болно. Мөн хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх шинэ боломжуудыг бий болгохдоо ТХХТ-ийг хөхиүлэн дэмжиж, итгэлцлийн сангуудаас хамтарсан санхүүжилт татах хүчин чармайлтаа нэмэгдүүлнэ. АХБ нь иргэний нийгэмтэй илүү нягт хамран ажиллаж, нэн ялангуяа мэдлэгт түшиглэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэх ба түгээх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд түлхүү оролцуулахад анхаарна. Түүнчлэн тинк-танк уулзалт, зөвлөгөөн, сургалт семинараар дамжуулан үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлэх замаар мэдлэгийн түншлэлүүдээ гүнзгийрүүлэх болно.

## **Г. АХБ-ны стратегийн болон сэдэвчилсэн зорилтууд, төрийн сектор болон хувийн хэвшилд хамаарах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**

26. **Монгол Улсад КОВИД-19 хямралыг даван туулж, хүртээмжтэй бөгөөд тогтвортой хөгжлийн бөх бат сууриа тавихад туслах нь түншлэлийн стратегийн үндсэн зорилго юм.** Энэ нь Засгийн газрын үндэсний хөгжлийн бодлоготой уялдсан бөгөөд үүний тулд АХБ дараах гурван стратегийн тэргүүлэх чиглэлд төвлөрөн ажиллана, үүнд: (i) хүртээмжтэй нийгмийн хөгжил ба эдийн засгийн боломжуудыг хөхиүлэн дэмжих, (ii) өрсөлдөх чадвар ба эдийн засгийн төрөлжилтийг дэмжих уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх; мөн (iii) ногоон бөгөөд уур амьсгалд зохицсон тогтвортой хөгжлийг цогцлоох (Зураг 1-ээс үзнэ үү). АХБ нь төрийн секторт хамаарах үйл ажиллагаа, ТХХТ, хувийн хэвшилд хамаарах үйл ажиллагаагаа бүх түвшинд нягт уялдуулж, мэдлэгт

<sup>14</sup> АХБ. 2018. Хөгжлийн хамтын ажиллагааны үр өгөөжийг сайжруулахаар Монгол Улсад үзүүлэх техникийн туслалцаа. *Монгол Улс дахь Хөгжлийн хамтын ажиллагааны үнэлгээ*. Улаанбаатар.

<sup>15</sup> Хамгийн том 5 хөгжлийн түнш: Япон Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн банк, Герман Улс. Эх сурвалж: Сангийн Яамны статистик.

түшиглэсэн шийдлүүдийг оновчтойгоор ашиглана. Банкнаас жендэрийн тэгш байдал, цахим шилжилт, хувийн хэвшлийн оролцоо, институцийн чадавх ба засаглал болон иргэний нийгмийн хамтын ажиллагаа гэсэн таван сэдэвчилсэн чиглэлд анхаарна. Түншлэлийн стратегийн хүрээнд 17 ТХЗ-ын 16 зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.


**27. АХБ төсөл хөтөлбөр сонгон хэрэгжүүлэхдээ нарийн шалгууруудыг баримтална.** Тухайлбал, үйл ажиллагаагаа эрэмбэлэн тодорхойлоход нарийвчлан сонгосон хэд хэдэн шалгуурыг ашиглах юм. Нэгдүгээрт, ойрын хугацаанд КОВИД-19 цар тахлын эсрэг арга хэмжээнд төвлөрч, эдийн засгаа тогтвортойгоор сэргээх Засгийн газрын хүчин чармайлтыг дэмжин, хүн амын хамгийн эмзэг хэсэг эдийн засгийн сэргэлтээс хоцрохгүй байхад анхаарна. Хоёрдугаарт, салбарын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг сонгохдоо хөгжлийн түнш байгууллагуудтай нягт хамтран ажиллана. Гуравдугаарт, үйл ажиллагаагаа газар зүйн байршлаар төвлөрүүлж, эхний ээлжинд Монгол Улсын баруун бүсийг<sup>16</sup> сонгон, хот хөдөө дахь төсөл хөтөлбөрүүдээ уялдуулах замаар хөгжлийн үр нөлөөг нь дээшлүүлнэ. Дөрөвдүгээрт, төслүүдийг сонгохдоо бэлэн байдлаар нь буюу хэрэгжихэд бэлэн төслийг эн тэргүүнд тавина. Эцэст нь Монгол Улсын хөгжлийн замналд хувийн хэвшлийн оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх үүднээс хувийн хэвшил оролцох хамгийн боломжтой төслүүдийг эн тэргүүнд хэрэгжүүлнэ.

**28. Цөөн, илүү том төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.** Нарийн шалгуурт аргачлалыг баримтлан, олгох зээлийн хэмжээг хэвэнд нь барихдаа төсөл хөтөлбөрийн тоог бууруулан, урт хугацааны хөгжлийн үр нөлөө бүхий томоохон, хөтөлбөрчилсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.<sup>17</sup> Боловсролын салбарт ур чадварын хөгжил, техник мэргэжлийн сургалт ба боловсролд төвлөрөх ба КОВИД-19 цар тахлын асуудлыг харгалзан суурь ба ерөнхий боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулахыг зорино. Хот байгуулалтын салбарын хувьд, үйл ажиллагааны төв Улаанбаатар хотоос хоёрдогч ба дагуул хотууд руу шилжиж, Монгол Улсын баруун аймгуудад төвлөрнө. Эрчим хүчний салбар дахь АХБ-ны үйл ажиллагаа бодлогын хэлэлцүүлэг, батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, инноваци, хувийн хэвшлийн оролцоо зэрэгт чиглэхийн зэрэгцээ сэргээгдэх эрчих хүчний үндэсний хөтөлбөрийг бүтээхэд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлнэ. Зам тээврийн салбарт төлөвлөгдсөн томоохон хөрөнгө оруулалтад авто зам ба төмөр замын бүтээн байгуулалтууд багтсан бол хөдөө аж ахуй, байгалийн баялаг ба хөдөөгийн хөгжлийн салбар дахь төсөл хөтөлбөрүүдийн цар хүрээг тэлнэ. Банкны зүгээс эрүүл мэндийн салбар дахь шинэ хөрөнгө оруулалтын тоог нэг болгон бууруулж, бодлогын шинэтгэл ба хэрэгжүүлэлтэд төвлөрнө. Нийгмийн хамгааллын чиглэлээр КОВИД-19 цар тахал дууссаны дараа шинэ хөрөнгө оруулалт хийхгүй бөгөөд одоогийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарна. Төрийн секторын удирдлагын хувьд шинээр эхлэх үйл ажиллагаа бодлогод суурилсан зээл (БСЗ)-ийн санхүүжилтийг багтаах ба макро эдийн засгийн шинэтгэлийг эрчимжүүлэх, жендэрийн тэгш байдлыг сайжруулахад чиглэсэн буцалтгүй тусламж олгох, төрийн үйлчилгээг цахимжуулан, хүртээмжийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын зээл олгох хэлбэртэй байна. АХБ нь бүс нутгийн хамтын ажиллагаа ба интеграцийг тэргүүлэх чиглэл хэвээр үргэлжлүүлэх ч одоогийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд төвлөрч, шинээр ердөө нэг төсөл нэмж хэрэгжүүлнэ.

<sup>16</sup> Баруун бүсийн Баян-Өлгий, Ховд ба Увс аймгуудыг эхэн үеийн цөм бүсээр тодорхойлсон хэд хэдэн шалтгаан бий. Тус аймгууд БНХАУ ба Оросон Холбооны Улстай замын сүлжээгээр холбогдсон тул эдийн засгийг нь төрөлжүүлэх суурь тавигдсаны зэрэгцээ мал аж ахуй сайтар хөгжсөн (хөдөлмөр эрхлэлтийн 38-51 хувийг бүрдүүлдэг. Түүнчлэн, байгаль орчны сорилт ихтэй бөгөөд бэлчээрийн даац хэтрэлтийн үзүүлэлт нь (27.4%) улсын дунджаас 5 хувиар өндөр.

<sup>17</sup> Одоогийн төлөвлөгөөр 2021-2024 оны түншлэлийн стратегийн хүрээнд хэрэгжих төсөл хөтөлбөрийн тоо (зээл, буцалтгүй тусламж ба ТТ төсөл) 2017-2020 оны түншлэлийн стратегитай харьцуулахад 20 гаруй хувиар буурна.

**Зураг 1: АХБ-ны 2021-2024 онд Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн тойм**



АХБ=Азийн Хөгжлийн Банк; КОВИД-19=коронавирусаар үүсгэгдсэн өвчин; МХТ=мэдээлэл, харилцааны технологи; БЖДҮ=бичил, жижиг ба дунд үйлдвэр, аж ахуйн нэгж; ББСБ=банк бус санхүүгийн байгууллага; ТХХТ=төр, хувийн хэвшлийн түншлэл.

Эх сурвалж: Азийн Хөгжлийн Банк.

## 1. Стратегийн тэргүүлэх чиглэл 1: Хүртээмжтэй нийгмийн хөгжил ба эдийн засгийн боломжуудыг хөхиүлэн дэмжинэ.

29. АХБ нь КОВИД-19 цар тахлыг даван туулж, хөгжлийн шинэ шатанд гарахад чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхдээ санхүүгийн хүртээмжийг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд ба ур чадварын хөгжлийг дэмжих, нийгмийн хамгааллын тогтолцоог төлөвшүүлэхэд анхаарна. КОВИД-19 хямралын эсрэг арга хэмжээг эрүүл мэнд ба нийгмийн хамгааллын салбарын дунд хугацааны шинэтгэлтэй уялдуулах замаар АХБ-наас инновацийг эрчимжүүлэхэд анхаарч, Монгол Улс ирээдүйд илүү сайхан нийгмийг цогцлоох суурийг тавихад нь дэмжлэг үзүүлнэ. Инновацийн бусад чиглэлд ногоон санхүүжилт, финтекийн хууль эрх зүйн зохицуулалт болон иргэний бүртгэлийн тогтолцоог сайжруулах зорилго бүхий цахимжуулалтын ажлууд багтана. Стратегийн тэргүүлэх чиглэл

1 нь хэд хэдэн Үйл ажиллагааны тэргүүлэх зорилт (ҮТЗ)-той уялдсан, үүнд: ҮТЗ 1 (ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг багасгах), ҮТЗ 2 (жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцыг эрчимжүүлэх), ҮТЗ 6 (засаглал ба институцийн чадавхыг бэхжүүлэх) ба ҮТЗ 7 (бүс нутгийн хамтын ажиллагаа ба интеграцийг хөхиүлэн дэмжих) зэрэгтэй нягт уялдсан болно.

30. **КОВИД-19 цар тахлыг даван туулахад тусална.** АХБ-наас вакцины худалдан авалт, ханган нийлүүлэлтийн дэд бүтэц ба шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтад дэмжлэг үзүүлнэ. Нэн тэргүүнд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийг худалдан авалт болон 82 хувийг нь эмэгтэйчүүд бүрдүүлдэг тэргүүн шугамын эмнэлгийн ажилтнуудын цалин урамшуулалд зориулж буцалтгүй тусламжийн хөрөнгийг дайчлах болно. Түүнчлэн, КОВИД-ын эсрэг Засгийн газраас авч буй арга хэмжээг дэмжихэд зориулж, БСЗ-ийн санхүүжилт олгож, эрүүл мэндийн салбарын шинэтгэлийг эрчимжүүлэхэд анхаарна. Үүний зэрэгцээ, ажиллах хүчнийг сургах, онцгой байдлын үед даган мөрдөх дүрэм журмыг сайжруулахад зориулж техникийн туслалцаа (ТТ) үзүүлнэ. АХБ нь КОВИД-19 цар тахлын эсрэг арга хэмжээний хүрээнд хувийн хэвшилд үзүүлэх дэмжлэг туслалцаагаа нэмэгдүүлнэ.

31. **Хүний хөгжил ба нийгмийн оролцоо.** Эрүүл мэндийн салбарт олон жил үйл ажиллагаа явуулсан туршлага дээрээ түшиглэн КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээг дэмжих БСЗ-ийн хүрээнд АХБ нэн тэргүүнд хийгдэх шаардлагатай шинэтгэлийг эрчимжүүлэх болно. Үүний зэрэгцээ, анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулахад хөрөнгө оруулалт хийж, салбарын төлөвлөлт, санхүүгийн тогтвортой байдал, эмнэлгийн бие даасан байдал болон худалдан авалтын тогтолцооны шинэчлэл зэрэг томоохон шинэтгэлийн чиглэлүүдэд тусгайлан боловсруулсан мэдлэгийн шийдлүүдийг нэвтрүүлнэ. АХБ нь КОВИД-19 цар тахлын эсрэг авсан нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдийг сууриа болгон нийгмийн халамжийн тогтолцоонд системийн сайжруулалт хийн, үр өгөөжийг нь нэмэгдүүлэхийг зорьж, дасан зохицох, цочролын үед шуурхай хариу арга хэмжээ авах системийн чадварыг бэхжүүлэхийн зэрэгцээ халамжийн тогтолцооноос хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр рүү шилжүүлэх аргачлалыг дэмжин ажиллах болно. Ингэхдээ, хувийн тэтгэврийн тогтолцооны суурийг тавих ажилд банкнаас ТТ үзүүлнэ. АХБ нь хөгжлийн бэрхшээлийн эрт оношилгоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж дэмжлэгийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийн боломжийг нэмэгдүүлэхэд анхаарна. ТТ үзүүлэх бусад чиглэлд боловсролын салбар ба хувийн хэвшлийн чиглэлээрх үйл ажиллагааны төлөвлөлт ба тогтвортой байдлыг сайжруулах асуудал багтсан. Хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт нийлүүлэлтийн уялдаагүй байдлыг шийдвэрлэх зорилгоор ур чадварын хөгжил болон дээд боловсролд Засгийн газрын зээл олгоно. Түүнчлэн, суурь ба ерөнхий боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхээр МХТ-д хөрөнгө оруулалт хийх болно. Энд дурдагдсан бүхий л үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусгана.

32. **Санхүүгийн салбарын тогтвортой байдал ба хөгжил.** АХБ нь банкны салбарын засаглал, тогтвортой байдал ба гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн Банкны салбарыг 2020-2023 онд чадавхжуулах хөтөлбөрийг<sup>18</sup> үргэжлүүлэн дэмжих болно. АХБ-наас Олон улсын валютын сан ба Дэлхийн банкт хамтран, салбарын реформын эрчийг алдахгүй байх шийдлүүдийг эрэлхийлж, БСЗ олгон, мэдлэгийн туслалцаа үзүүлнэ. АХБ нь жижиг болон албан бус бизнесийн хувьд банк бус санхүүгийн салбар нэн чухал гэдгийг харгалзан тус салбарыг бэхжүүлэх чиглэлд үргэлжлүүлэн анхаарна. Эдгээр арга хэмжээг хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа болон АХБ-наас боловсруулан гаргасан Монгол Улсын Бондын зах зээлийн хөтөч нь дэмжих юм. Түүнчлэн, бүсийн шилдэг туршлагаудад түшиглэн эрсдэлийн зохистой удирдлагыг хослуулсан шинэ технологи,

<sup>18</sup> Монголбанк. 2020. *Банкны салбарыг чадавхжуулах дунд хугацааны хөтөлбөр, 2020-2023.*

бүтээгдэхүүн, үйлчилгээ (ногоон санхүүжилт, эрсдэлийн гамшгийн эсрэг санхүүжилт, финтек гэх мэт) зэргийг хөхиүлэн дэмжих оновчтой шийдлүүдийг эрэлхийлэх болно.

**33. Хувийн хэвшлийн хөгжлийг эрчимжүүлнэ.** АХБ нь хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх Засгийн газрын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх замаар бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд анхаарна. Үүний тулд, банкнаас мэдлэгийн дэмжлэг болон БСЗ олгож, нэн ялангуяа эмэгтэй бизнес эрхлэгч болон агробизнес эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарахдаа хөгжлийн олон талт банкуудтай нягт хамтран ажиллаж бизнесийн зөвлөх үйлчилгээний дэмжлэг үзүүлнэ. АХБ нь хувийн хэвшилтэй хамтарсан төслүүдийнхээ хүрээнд хувийн хэвшлийн хөгжилд шууд дэмжлэг үзүүлэх бөгөөд дотоодын арилжааны банкуудаар дамжуулан зээлийн тусгайлсан шугамын эх үүсвэрүүдийг олгоно. Банкнаас Худалдааны санхүүжилтийн хөтөлбөрөө өргөжүүлэн, Монголын банкуудтай зээл ба зээлийн баталгааны бүтээгдэхүүн хамтран гаргаж, шинээр банкны түншлэлүүд бий болгох, худалдаа ба ложистикийн сүлжээний санхүүжилт, жөндөр, хамгааллын тогтолцоо, мөнгө угаахтай тэмцэх ба нийцлийг хангах чиглэлээр чадавхыг бэхжүүлэх ТТ үзүүлэхэд анхаарна.

## **2. Стратегийн тэргүүлэх чиглэл 2: Өрсөлдөх чадвар ба эдийн засгийн төрөлжилтийг дэмжих уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлнэ.**

**34.** АХБ нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор холболтын дэд бүтцэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн. Үүний үр дүнд Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулж, хөдөө орон нутагт тогтвортой хөгжлийг эрчимжүүлэх боломжууд нээгдэнэ. Эдгээр хөрөнгө оруулалтад арчилгаа үйлчилгээний асуудлыг давхар суулгах аргачлалыг хэрэгжүүлэн, уур амьсгалд тэсвэртэй шийдлүүдийг нэвтрүүлэх ба ногоон технологи түлхүү ашиглах, дэд бүтцийн салбарт хувийн хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хамтарсан санхүүжилтийн боломжуудыг ашиглана. Стратегийн чиглэл 2 нь Стратеги 2030-н ҮТЗ 4 (хот, суурин газрын амьдрах орчныг сайжруулах), ҮТЗ 5 (хөдөөгийн хөгжил ба хүнсний баталгаат байдлыг бэхжүүлэх) ба ҮТЗ 7 (бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийг хөхиүлэн дэмжих) зэрэгтэй бүрэн уялдсан ба дэд бүтцийн санхүүжилтэд төвлөрөх тул түншлэлийн стратегийн хугацаанд АХБ-ны төсөл хөтөлбөрийн багцын хамгийн том бүрэлдэхүүн хэсэг болно.

**35. Холболтод хөрөнгө оруулах.** АХБ нь тээврийн салбарын амжилттай туршлагадаа түшиглэн, бүс нутгийн автозамын сүлжээг хөгжүүлэх болон хот суурин газар ба хилийн томоохон боомт хоорондын холболтыг сайжруулах үйл ажиллагааг дэмжинэ. Түүнчлэн, АХБ нь Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах замаар эдийн засгийг эрчимжүүлэн, агаарын бохирдлыг бууруулна. Банкнаас зээлийн санхүүжилтийн болон холбогдох мэдлэг шилжүүлэх үйл ажиллагаагаараа дамжуулан замын хөдөлгөөний аюулгүй байдал болон автозамын арчилгаа үйлчилгээг сайжруулахад үргэлжлүүлэн анхаарна. Зам тээврийн салбар дахь үйл ажиллагаа уур амьсгалд тэсвэртэй техник технологийг ашигласнаар зорчигч ба бараа тээвэрлэлтэд нэн чухал замуудын ашиглалтын эдэлгээ ба тогтвортой байдлыг бэхжүүлнэ. Ийм техник технологийн шийдлүүдэд мөнх цэвдэг хайлах, аадар бороо олширч үерийн аюул олшрох, хөрсний халалт ихсэх, цасан болон шороон шуурганы давтамж нэмэгдэх зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг харгалзах болно. Түүнчлэн, татвар, аудит, иргэний бүртгэл зэрэг төрийн үйлчилгээг цахимжуулахад хөрөнгө оруулна.

**36. Хот-хөдөөгийн хэлхээ холбоог бэхжүүлэх уур амьсгалд зохицсон дэд бүтэц.** АХБ нь зээлийн санхүүжилт ба техникийн туслалцаагаар дамжуулан хот, суурин газар, гэр хороолол, хөдөө орон нутагт хатуу болон зөөлөн дэд бүтцийг өргөжүүлэхэд анхаарна.

Ингэснээр, ус хангамж, ариутгах татуурга зэрэг нийтийн аж ахуйн суурь үйлчилгээний хомсдолыг багасгаж, амьжиргааны шинэ эх үүсвэрүүдийг бий болгон, хүртээмжтэй, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийг цогцлооход түлхэц өгнө. Банкнаас ТХХТ-г дэмжин, орчны дэд бүтэц, хотын сэргээн босголт, ложистик ба уул уурхайн ханган нийлүүлэлтийн сүлжээ зэрэг чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад анхаарна. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах зорилгоор Засгийн газарт зээл олгож, бусад хотуудыг хөгжүүлэн, зам тээврийн зангилаа байршлуудад ойр эдийн засгийн идэвхтэй бүсүүдийг байгуулахад хөрөнгө оруулна. Ингэхдээ, жендэрийн мэдрэмжтэй, иргэдийн оролцоотой хот төлөвлөлтийг дэмжих мэдлэгт түшиглэсэн шийдлүүдийг нэвтрүүлнэ.

**37. Бүс нутгийн хамтын ажиллагаа ба интеграци.** АХБ нь хилийн боомтуудын дамжин нэвтрүүлэх чадварыг сайжруулж, стратегийн байршил бүхий эдийн засгийн бүсүүдэд хил дамнасан эдийн засгийн коридоруудыг хөгжүүлэхэд анхаарна. Үүний зэрэгцээ экспорт ба гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор худалдааны салбарын удирдлага ба бодлогыг бэхжүүлэх ТТ хэрэгжүүлж, бизнесийн таатай орчин бүрдүүлэх үйл ажиллагаанд анхаарна. АХБ нь Монгол Улсын Төв Азийн Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа буюу КАРЕК-т оролцох оролцоог үргэлжлүүлэн дэмжиж, бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн, худалдааны боломжуудыг өргөжүүлэн тэлэхэд анхааран ажиллана. АХБ нь экспортыг тэлэх зорилгоор агробизнес ба аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх үйл ажиллагаагаа гүнзгийрүүлнэ. Ингэхдээ, зорчигч ба бараа бүтээгдэхүүний хил дамнасан урсгалаас улбаатай эрсдэлд тэсвэртэй байдлыг бэхжүүлсэн орон нутаг дахь төрийн үйлчилгээг дэмжин ажиллана. Түүнчлэн, бүс нутгийн эрчим хүчний сүлжээ байгуулах үйл хэрэгт дэмжлэг тусалцааг үргэлжлүүлэн үзүүлж, Өмнийн Говийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг экспортын чиг баримжаатайгаар хөгжүүлэх ажилд туслах болно.

### **3. Стратегийн тэргүүлэх чиглэл 3: Ногоон бөгөөд уур амьсгалд зохицсон тогтвортой хөгжлийг цогцлооно.**

**38.** АХБ нь тэсвэртэй байдлыг бэхжүүлэхэд, тэр дундаа макро эдийн засгийн тэсвэртэй байдлыг бэхжүүлэхэд анхаарч, нөөцийн зохистой ашиглалт, ногоон хөгжлийг дэмжинэ. Энэхүү тэргүүлэх чиглэлийн хүрээнд Засгийн газартай нягт хамтран ажиллаж, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангахад (тайлбар 13-г үзнэ үү) дэмжлэг үзүүлэх ба ногоон хөгжлийг цогцлоох, нэн ялангуяа нүүрсний хэрэглээнээс аажмаар татгалзах, мал аж ахуйн сайн туршлагыг нэвтрүүлэх, байгалийн нөөцийн хэтийдсэн хэрэглээ давамгайлж ирсэн хөгжлийн замналыг өөрчлөхөд тусална. АХБ нь Монгол Улсын байгалийн баялгийн үнэ цэнэ ба ашиглалтын талаарх шийдвэр гаргалтыг илүү шинжлэх ухаан суурьтай, мэдээлэлд үндэслэсэн болгох, мөн өсөлт хөгжлийг илүү тогтвортой, цочролд тэсвэртэй болгох чиглэлээр шинэлэг шийдлүүдийг санал болгоно. Стратегийн тэргүүлэх чиглэл 3 нь Стратеги 2030-ийн ҮТЗ 3 (уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, уур амьсгал ба гамшгийн сөрөг нөлөөнд тэсвэртэй байдлыг хөгжүүлэх болон байгаль орчны тогтвортой байдлыг бэхжүүлэх), ҮТЗ 5 (хөдөөгийн хөгжил, хүнсний аюулгүй байдлыг дэмжих) ба ҮТЗ 6 (засаглал ба институцийн чадавхыг бэхжүүлэх) зэрэгтэй уялдсан болно.

**39. Макроэдийн засгийн удирдлага ба дотоод эх үүсвэрийн ашиглалт.** Хөтөлбөрчилсөн БСЗ-ээр дамжуулж, өмнөх үеийн үйл ажиллагааны ба мэдлэгийн туршлагадаа түшиглэн, АХБ нь төрийн нөөцийн удирдлагын үр ашиг ба тэгш хүртээмжийг дээшлүүлэх (үүнд татварын бодлого боловсруулалт ба удирдлага, байгалийн нөөцийн зохистой үнэлгээ ба байгалийн баялгийн орлого ба өрийн удирдлагыг сайжруулах замаар дотоодын эх үүсвэрийг илүү үр өгөөжтэйгээр ашиглах чиглэл багтана) зорилготой гол гол шинэтгэлийг дэмжиж, уул уурхайн бус салбарын хувийн хэвшилд таатай орчин бүрдүүлэх,



санхүүгийн салбарын тогтвортой байдал ба цаашдын хөгжлийг хөхиүлэн дэмжих зэрэг чиглэлд ажиллана. АХБ нь санхүүгийн шинэлэг шийдэл санал болгох чадвартаа түшиглэн хэсэгчилсэн эрсдэлийн хариуцлага ба зээлийн баталгаа, хосолсон санхүүжилт зэрэг бүтээгдэхүүн санал болгоно. Түүнчлэн, тодорхой тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад хөтөлбөрчилсөн БСЗ-ийн тусламжтайгаар бодлогын шинэтгэлийг үргэлжлүүлэхдээ эрүүлийг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр бий болгосон эерэг туршлагаудаа ашиглана.

**40. Тогтвортой агробизнес ба аялал жуулчлал.** АХБ нь газар тариалангийн үр шим, усны зохистой ашиглалтыг сайжруулах зорилгоор уур амьсгалд тэсвэртэй усалгааны технологи нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн Монгол Улсын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох зорилгод туслах зорилгоор бэлчээрийн зохистой ашиглалт, мал аж ахуйн менежмент, малын өтөг бууцын боловсруулалтыг дэмжиж, мал аж ахуйн салбарт хөрөнгө оруулна. Мөн АХБ нь бүтээмжийг дээшлүүлэх, уур амьсгалд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах зорилгоор агробизнесийн ханган нийлүүлэлтийн сүлжээ, хүнсний бүтээгдэхүүний мөшгилтийн тогтолцоо, хөдөө аж ахуйн салбарын логистик ба бүтээгдэхүүний зохистой хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэхэд анхаарна. АХБ нь тогтвортой аялал жуулчлалд үргэлжлүүлэн хөрөнгө оруулах бөгөөд салбарын үндэсний стратегийн төлөвлөгөө боловсруулах ажилд туслалцаа үзүүлнэ. Түүнчлэн бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг бүтээгдэхүүн ба ханган нийлүүлэлтийн сүлжээгээ “ногооруулах”, зохистой хэрэглээ ба үйлдвэрлэлийн практикийг нэвтрүүлэхэд нь дэмжин ажиллана.

**41. Цэвэр цахилгаан ба дулааны эрчим хүч.** АХБ нь санхүүжилт ба мэдлэг шилжүүлэх дэмжлэгээр дамжуулан дулаан хангамжийн цэвэр технологийг илүү өргөнөөр ашиглахыг хөхиүлэн дэмжинэ. Банкнаас цахилгаан ба дулаан хангамжийн шугам сүлжээг шинэчлэх, төрийн байгууллагуудын гүйцэтгэлийн чадавхыг бэхжүүлэх замаар сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх, эрчим хүчний системийн уян хатан зохицуулалтыг сайжруулах зэрэгт туслалцаа үзүүлнэ. Монгол Улсын Өмнийн говийн бүсээс гадаад улс орнууд руу сэргээгдэх эрчим хүч экспортлох нөөц бололцоог хөгжүүлэхэд Засгийн газарт зээл олгох бөгөөд ингэснээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн бүсийн түвшний үйл ажиллагаанд энэхүү аргачлалын оруулах хувь нэмрийг таниулан сурталчлах болно.

**42. Орчны бохирдлыг бууруулна.** АХБ нь эрчим хүч ба байгалийн нөөцийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, тэр дундаа хотын агаарын бохирдолтой тэмцэх зорилгоор хот суурин газрууд дахь нүүрстөрөгчийн ялгарал ба эрчим хүчний хэт хэрэглээг бууруулах чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллана. Ингэхдээ төсөл хөтөлбөрүүдэд дулаан ба эрчим хүчний цэвэр эх үүсвэрийн ашиглалтын шаардлага шалгуурыг суулган, агаарын бохирдлыг бууруулах үйл хэрэгт нэмэлт хувь нэмэр оруулах болно. Ус, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор хатуу хог хаягдал цуглуулах, дахин ашиглах, боловсруулах чиглэлд банкнаас хөрөнгө оруулж, эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулахад анхаарна. Түүнчлэн агаар, ус, хөрсний бохирдлын талаарх холбогдох дүрэм журам, стандартыг сайжруулах, хяналт шалгалтын тогтолцоо бүрдүүлэхэд Засгийн газарт дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

**43. Уур амьсгал ба гамшигт тэсвэртэй байдал.** АХБ нь гамшгийн эрт дохиоллын системийг бий болгох, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийг сайжруулах, суурь дэд бүтэц ба хөдөөгийн оршин суугчдын амьжиргааны чанар ба тэсвэртэй байдлыг бэхжүүлэх чиглэлээр Засгийн газарт дэмжлэг үзүүлнэ. Банкнаас уур амьсгалын өөрчлөлтийн цар хүрээ, гамшгийн хор уршгийн үнэлгээ хийх мэдлэгийн дэмжлэгээр хангаж, нэн ялангуяа хөдөөгийн иргэд болон эмэгтэйчүүдийн тэсвэртэй байдлыг сайжруулах

шинэлэг шийдлүүдийг нэвтрүүлнэ. Түүнчлэн АХБ нь өөрийн мэдлэгийн баазыг ашиглан, Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргийн<sup>19</sup> дагуу нүүрстөрөгчийн ялгарал бага, уур амьсгалд тэсвэртэй хөгжлийг цогцлоох урт хугацааны стратегийг боловсруулан хэрэгжүүлэхэд чиглэсэн Засгийн газрын үйл ажиллагааг дэмжин, уур амьсгалын асуудлуудыг хөгжлийн бүх шатны төлөвлөгөөндөө тусган, нүүрстөрөгчийн ялгарал бага, ногоон хөгжлийн замналаар урагшлахад шаардлагатай нөөц бололцоог дайчлахад тусална.

**44. Ус ба байгалийн бусад нөөцийн удирдлагыг сайжруулна.** АХБ нь усны нөөцийн нэгдсэн удирдлагыг сайжруулах, мал аж ахуйн ба газар тариалангийн усалгаа болон хот суурин, аж үйлдвэрийн салбарын хэрэглэгчдэд зориулж гадаргын болон гүний усны эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлэх, усны бохирдол ба усаар дамжих өвчлөлөөс сэргийлэх, экосистемийг хамгаалах зэрэгт нэн шаардлагатай дэд бүтэц болон институцийн чадавхийг бий болгоход Монгол Улсад дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн, бэлчээрийн доройтол ба цөлжилтөөс сэргийлэх, ой мод, намгархаг газруудыг хамгаалахын тулд бэлчээрийн менежментийг сайжруулахад анхаарна.

#### 4. Сэдэвчилсэн чиглэлүүд

**45. Хувийн хэвшилд хамаарах үйл ажиллагаа.** АХБ-ны 2019-2024 оны Хувийн хэвшлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус банкнаас Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоог нэмнэ гэж тусгасан. Ингэхдээ зээл болон хувьцааны хөрөнгө оруулалтаас гадна, лизингийн болон бичил санхүүгийн байгууллага гэх мэт арилжааны банк болон банк бус санхүүгийн салбарт санхүүжилт олгох замаар түншлэлийн стратегийн тэргүүлэх чиглэлүүдийн хэрэгжилтийг дэмжинэ. Түүнчлэн “Худалдаа, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт” хөтөлбөрийнхөө хүрээнд баталгаа болон зээлийн бүтээгдэхүүнээрээ дамжуулан хөгжиж буй Ази тивийн улс орнуудтай хийх олон улсын худалдааг хөхиүлэн дэмжинэ. АХБ нь түнш банкууддаа жендэр ба хамгаалал зэрэг сэдвийн хүрээнд ТТ үргэлжлүүлэн үзүүлнэ.

**46. Төр, хувийн хэвшлийн түншлэл.** АХБ нь “Нэг АХБ” платформуороо дамжуулж, бизнесийн таатай орчин бүрдүүлэхэд системийн дэвшил гаргах зорилгоор төрийн салбарт мэдлэгийн<sup>20</sup> болон БСЗ-ийн дэмжлэг үзүүлэн хувийн хэвшилд хамаарах үйл ажиллагаагаа дэмжих бөгөөд ингэхдээ хувийн хэвшилд хамаарах үйл ажиллагаагаараа хуримтлуулсан практик туршлагаа дайчилна. Банкны ТХХТ-ийн чиглэлээрх мэдлэгийн үйл ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг бол “Монгол Улсын ТХХТ-ийн монитор” хэмээх ТХХТ-тэй холбоотой АХБ-ны бүхий л үйл ажиллагаанд даган мөрддөг цогц оношилгоо, үнэлгээний гарын авлага юм. АХБ нь ТХХТ-ийг хөгжүүлж, төрийн хөрөнгө оруулалтын менежментийн тогтолцоонд нэвтрүүлэхэд шаардагдах зохицуулалтын шинэтгэлийн ажилд техникийн туслалцаа үзүүлнэ. Цаашид тэсвэртэй байдал ба өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын өгөөж өгөх төслийн саналуудыг цуглуулах, үнэлэн шалгаруулах, ач холбогдлоор нь эрэмбэлэх чадавхыг төрийн байгууллагуудад эзэмшүүлэх чиглэлээр банкнаас дэмжин ажиллана. Ингэхдээ ТХХТ-ийн эрх зүйн орчны хүрээнд хэрэгжүүлэх боломжтой үр ашигтай төслүүдийг эрэмбэлэн сонгох чиг үүрэг бүхий төсөл боловсруулах нэгж байгуулах асуудлыг авч үзнэ. Хэрэгжилтийн тал дээр, АХБ нь санхүүжилтийн зөвлөгөө өгөх болон зээлийн баталгаа гаргах чадавхаа идэвхтэй ашиглаж, банкны шаардлага хангасан төслүүдийг хувийн хөрөнгө оруулалтын зах зээлтэй холбох болно. Ингэснээр шаардлагатай шинэчлэл өөрчлөлтийн талаарх ойлголт, дэмжлэг ба итгэл үнэмшил сайжирч, хувийн хэвшлийн

<sup>19</sup> Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенци. 2015. *Парисын хэлэлцээр*. Парис хот.

<sup>20</sup> Үүнд хувийн хэвшилд хүрч ажиллах, төслийн бэлэн байдлыг хангах, ХХҮА хэрэгжүүлэх МШТТ багтсан.

хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх бодлогын шинэтгэл, тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох шийдвэр гаргахад дэмжлэг болно.

47. **Жендэрийн тэгш байдлыг хангахад гарч буй ахиц дэвшлийг эрчимжүүлнэ.** АХБ нь тусгайлсан төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн болон бодлогын шийдвэрийн биелэлтэд дэмжлэг үзүүлэх болно. Жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллана. Цаашлаад Үйл ажиллагааны тэргүүлэх зорилт 2-ын хүрээнд санхүүгийн хүртээмж, нийгмийн хамгаалал, агробизнес зэрэг төр болон хувийн хэвшлийн төслүүдийн үйл ажиллагаанд жендэрийн асуудлыг уялдуулан тусгана. Эдийн засгийн урт хугацааны болоод хүртээмжтэй өсөлтийг хөхиүлэн дэмжих үүднээс АХБ эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг дэмжих болон хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдлэг ба бодлогын хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулсан хэвээр байх болно.

48. **Цахим шилжилт ба өндөр түвшний технологи.** Засгийн газар цахим шилжилтийг тэргүүн зорилгоор тодорхойлж, цахимжуулах асуудал хариуцсан яамыг байгуулахаар төлөвлөж байна. АХБ нь иргэний бүртгэл, татвар ба бусад төрлийн төрийн үйлчилгээг цахимжуулахад үргэлжлүүлэн хөрөнгө оруулахын сацуу худалдаа, финтек, боловсрол, эрүүлийг хамгаалах ба агробизнесийн чиглэлээрх үйл ажиллагаандаа цахим шийдлийг аль болох боломжийн хэрээр нэвтрүүлэхийг зорьж ажиллана. Цахимжуулах асуудал хариуцсан төрийн яам байгуулагдахад банкнаас түүнтэй хамтран ажиллаж, мэдээллийн чанар ба аюулгүй байдлыг хамгаалахын зэрэгцээ хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжсэн зохицуулалтын орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. АХБ өөрийн үйл ажиллагаагаар дамжуулан, агробизнес, эрүүлийг хамгаалах, финтек, аялал жуулчлал, зочдод үйлчлэх зэрэг янз бүрийн салбарт цахим шийдлүүдийг нэвтрүүлэхээр зорин ажиллана.

49. **Иргэний нийгмийн хамтын ажиллагааг тэлэх.** АХБ нь түншлэлийн стратегийг боловсруулахдаа ИНБ-уудтай хийсэн өргөн хэлэлцүүлгийн үр дүнд түшиглэсэн бөгөөд цаашид ИНБ-уудтай хамтын ажиллагаагаа тэлэхэд анхаарч ажиллана. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд төслийг боловсруулах ба хэрэгжүүлэх ажлыг сайжруулах, үр өгөөж хүртэгчдийн эргэх холбоо ба иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, улмаар жендэр, нийгэм, байгаль орчны хамгааллын асуудлыг тусгах ажлыг илүү өргөтгөх зорилго тавьсан. АХБ өөрийн төсөл, хөтөлбөрийн стратегийг нотолгоонд суурилсан, нийгмийн тэргүүлэх чиглэл, иргэд олон нийтийн хэрэгцээнд нийцүүлсэн байлгах үүднээс 2019 онд Иргэний нийгэмтэй зөвлөлдөх хороог Монгол Улсад байгуулсан. Энэхүү хороогоор дамжуулан АХБ ИНБ-ын хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлнэ.

50. **Институцийн чадавх ба засаглал.** АХБ нь макро эдийн засгийн болон төсвийн удирдлага, төрийн сангийн төлбөр тооцооны систем, өрийн удирдлага, орлого бүрдүүлэлт ба хөрөнгө оруулалтын орчны шинэтгэл зэрэг чиглэлийг дэмжин ажиллана. АХБ нь (i) татвар ба дотоод эх үүсвэрийн бүрдүүлэлт, аудит, худалдан авах ажиллагаанд төвлөрч, төрийн санхүүгийн удирдлагыг бэхжүүлэх, болон (ii) Олборлох салбарын ил тод байдлын санаачлагатай хамтран ажиллах замаар уул уурхайн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, мөнгө угаахтай тэмцэх ажлыг өргөжүүлэн авилгын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарна. Мөн төслүүдийнхээ үйл ажиллагаагаар дамжуулан чадавх бэхжүүлж, институцийн болон журам зааврын шинэтгэлийг дэмжин, орон нутгийн засаг захиргаа зэрэг төрийн институцийн чадавхыг бэхжүүлэхэд тэргүүн ач холбогдол өгнө.

#### **Д. Мэдлэг солилцох үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**

51. **Мэдлэгийн дэмжлэг нь бодлого боловсруулахад ашиглагдахуйц, шинэлэг, чанартай судалгаа ба үнэлгээнд түшиглэсэн байхад төвлөрнө.** АХБ нь Монгол Улсад мэдлэгт түшиглэсэн шийдэл боловсруулахдаа (i) бодлогын талаар зөвлөмж гаргах; (ii) үнэлгээг сайжруулан инновацийг нэвтрүүлэх замаар үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх; (iii) засгийн газрын үйл ажиллагаа ба ИНБ-ын хоорондын харилцан санал солилцох холбоог сайжруулах; (iv) харилцагч байгууллагын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх зэргийг анхаарна. Ингэхдээ, төрийн салбарт хамаарах үйл ажиллагаандаа түшиглэн бизнесийн орчинг сайжруулах хүчин чармайлтаа тэлснээр, ирээдүйн ИНБ-д шинэ боломжуудыг нээнэ. ИНБ-аас хуримтлуулсан мэдлэг туршлагаа эргээд Засгийн газартай хийх хамтын ажиллагаандаа ашигласнаар бизнесийн орчин дахь эерэг өөрчлөлтүүдийг эрчимжүүлнэ. АХБ нь Засгийн газар, хөгжлийн түншүүд, иргэний нийгэм болон бусад оролцогч талуудтай мэдлэг солилцох түншлэлээ гүнзгийрүүлж, өргөн хүрээний хэлэлцүүлгийг өрнүүлэн, Монгол Улсад мэдлэгийг боловсруулан гаргах чадавхыг хөгжүүлнэ. Түүнчлэн АХБ өөрийн төсөл хэрэгжүүлсэн туршлагаас хуримтлуулсан сургамжийг бусадтай хуваалцах чадавхыг дээшлүүлэх замаар үнэлгээний жишээгээр үлгэрлэн манлайлах болно. Түншлэлийн стратегийн нэг хэсэг болох Монгол Улсад зориулсан мэдлэг шилжүүлэх төлөвлөгөөг стратегийн болон сэдэвчилсэн тэргүүлэх чиглэлүүдтэй бүрэн уялдуулсан бөгөөд 2-р хавсралтад танилцуулсан болно.

### **IV. СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТ**

#### **А. Хөрөнгийн ерөнхий тойм үзүүлэлт**

52. Монгол Улс нь ердийн хөрөнгийн эх үүсвэр (ЕХЭҮ)-ээс санхүүжилт авдаг улс бөгөөд ЕХЭҮ-ийн хөнгөлөлттэй болон энгийн зээлд хамрагдах эрхтэй.<sup>21</sup> АХБ нь 2021-2024 оны түншлэлийн стратегийн хугацаанд багтсан, Засгийн газарт олгох санхүүжилт бүхий төсөл хөтөлбөрт шаардагдах хөрөнгийг энгийн ба хөнгөлөлттэй нөхцөлтэй ЕХЭҮ-ээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн. 2021-2024 онд хөнгөлөлттэй ЕХЭҮ-ийн хувьд нийт 269 сая ам.долларын эх үүсвэр бүрдэх төлөвтэй байна. Түүнчлэн Азийн хөгжлийн сангийн буцалтгүй тусламж гэх мэт бусад эх үүсвэрээс хамтарсан санхүүжилтийн болон бусад хэлбэрийн хөрөнгө мөнгө дайчлах боломжуудыг эрэлхийлнэ. АХБ-наас одоогийн зардал хуваах тохиролцоонд өөрчлөлт оруулж, АХБ-ны санхүүжилтийн хэмжээг төсөл хөтөлбөрөөс хамаарч 99 хувиас 90 хувь болгон бууруулах ба энэ нь одоо хэрэгжиж буй аргачлал юм. АХБ нь Монгол Улсын төсвийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг дотоодоосоо санхүүжүүлэх чадварыг нь бэхжүүлэх үүднээс дотоодын эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлэх явдалд онцгой анхаарч дэмжлэг үзүүлнэ.

#### **Б. Хэрэгжилтийн явцад анхаарах асуудлууд**

53. **Төслийн хэрэгжилтийг сайжруулах нь.** АХБ нь төсөл батлах үед зураг дизайн болон худалдан авах ажиллагаа нь бэлэн болсон байх төслийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч, “Бага хэмжээтэй зардлыг санхүүжүүлэх хөтөлбөр” хэмээх зээл олгоно.<sup>22</sup> АХБ нь төслийг хэрэгжүүлэхэд гарах удаашралтыг багасгах үүднээс урьдчилсан худалдан авах ажиллагааг ашиглана. Төслийн хэрэгжилтийг эхлүүлэхэд саатал гаргахгүйн тулд (i) АХБ-ны

<sup>21</sup> Ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай (1.90 америк доллар) иргэдийн тоо болон нэг хүнд ногдох орлогын үзүүлэлтээс хамаарч Монгол Улс 2020 оны 6-р сард Дэлхийн банкны олон улсын хөгжлийн тусламжийн санхүүжилт авах улс орны ангиллаас гарсан.

<sup>22</sup> Энэ нь Засгийн газраас анх удаа төслийн бэлтгэлд шаардагдах зардалд зориулан зээл авахыг зөвшөөрсөн явдал бөгөөд төслийн хэрэгжилтийг сайжруулахаар авч байгаа үүрэг амлалтын илрэл болно.

санхүүжилттэй төсөлд урьдчилан худалдан авах ажиллагааг хэрэглэхдээ засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглах, (ii) төслийн гүйцэтгэлийг сайжруулах, төрийн байгууллагуудын худалдан авах ажиллагааны болон гэрээний удирдлагын чадавхыг бэхжүүлэх, (iii) засгийн газрын санхүүжилтэд тавих шаардлагуудыг зөөлрүүлэх зэрэг практик арга хэмжээг авна. АХБ нь эрсдэлд суурилсан аргачлалыг баримтлан, эрсдэл ба/эсвэл үнэ өндөр гэрээг урьдчилан хянаж, харин эрсдэл ба/эсвэл үнэ бага гэрээг түүврийн аргаар дараа хянах замаар ажиллана. Ингэснээр, зээлдэгч төслийн хэрэгжилтийн хариуцлагыг илүү ихээр хүлээх болно. АХБ нь төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор төсөл удирдах үүргийг төслийн хэрэгжилтийн хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх туршлага, чадамж сайтар бүрдсэн Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газарт илүүтэйгээр шилжүүлнэ. Ингэхдээ салбар болон техникийн мэргэжилтнүүдийг төвөөс суурин төлөөлөгчийн газарт байршуулан ажиллуулж, дэмжлэг үзүүлнэ.

54. **“Нэг АХБ” арга зарчим.** АХБ нь түншлэлийн стратегийн хэрэгжилтэд “Нэг АХБ” аргачлалыг бүх шатанд нь нэвтрүүлж, үйл ажиллагааны төлөвлөлтийг бүхэлд нь “Нэг АХБ” зарчмаар хийхдээ, төрийн ба хувийн хэвшлийн зээл, буцалтгүй тусламж, ТТ, зөвлөх үйлчилгээ, мэдлэгийн шийдэл зэрэг АХБ-ны арга хэрэгслүүдийг бүрэн хэмжээгээр дайчилж, Засгийн газар, хувийн хэвшлийн болон төрийн өмчийн байгууллагуудад иж бүрэн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

55. **Инновацийг эрхэмлэнэ.** АХБ нь олон жил ажиллаж, туршлага хуримтлуулсан салбарууддаа инноваци ба суурь өөрчлөлтүүдийг эрчимжүүлнэ. Тухайлбал, автозамын дэд бүтцийн төслүүдэд засвар арчилгааг оруулах, татварын удирдлага, гааль, иргэний бүртгэлийн салбарт цахим шийдлүүдийг нэвтрүүлэх зэрэг шинэлэг арга ажиллагааг хэрэгжүүлнэ. Түүнчлэн, санхүүжилтийн бусад эх үүсвэр татан төвлөрүүлэх чадвараа ашиглан инновацийг хөхиүлэн дэмжихийн зэрэгцээ орон нутагт тогтвортой хөгжлийг цогцлооход уур амьсгалын санхүүжилтийн боломжуудыг дайчлах зэрэгт анхаарна. АХБ нь цөөн тооны төсөл сонгон, шинэлэг санааг шууд нэвтрүүлэх бөгөөд үүнд гамшгийн эрсдэлийн удирдлагыг санхүүжүүлэх зээл болон тогтвортой аялал жуулчлалыг гүнзгийрүүлэх үйл ажиллагаа багтана. Түүнчлэн ТТ-ны хүрээнд инновацийг дэмжихдээ, (i) зүүн хойд Азийн бусад орнууд руу сэргээгдэх эрчим хүч гаргах түшиц газрыг Монгол Улсад байгуулах, (ii) АХБ-ны байгалийн капитал сангийн туршилтын санаачлагад Монгол Улсыг хамруулах, (iii) хувийн хөрөнгө оруулалт татах зорилгоор ТХХТ-ийн бүтцийг хөгжүүлэх, (iv) финтекийн эрх зүйн орчныг төлөвшүүлэхэд туслах зэрэг ажлуудыг хийнэ.

## **В. Үр дүнгийн хяналт**

56. АХБ нь 1 дүгээр хавсралтад танилцуулсан үр дүнгийн матриц дахь үзүүлэлтүүдээр түншлэлийн стратегийн хэрэгжилтийн явцыг үнэлэн дүгнэнэ. Түүнчлэн жил бүрийн хөтөлбөрийн үнэлгээ болон түншлэлийн стратегийн дунд хугацааны үнэлгээ хийх үед шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулна.

## **Г. Тулгарч болзошгүй эрсдэлүүд**

57. **Эдийн засгийн тогтворгүй байдал ба макро эдийн засгийн удирдлага.** Монгол Улсад макро эдийн засгийн удирдлагын зохистой тогтолцооны суурь үндсэндээ бүрэлдсэн билээ. Гэхдээ, хэрэгжилт алаг цоог байгаа нь өрийн удирдлага болон санхүүгийн салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. АХБ нь энэхүү түншлэлийн стратегийн хүрээнд тус хоёр салбар болон макро эдийн засгийн зохицуулалтын тогтолцоонд шинэтгэл хийх ажлыг тэргүүний чиглэлээр тодорхойлсон.

58. **Худалдан авах ажиллагаа.** АХБ-наас 2017 онд Монгол Улсын худалдан авах ажиллагааны тогтолцоонд хийсэн үнэлгээнээс хойш энэ тогтолцоонд гарсан ахиц дэвшлийг дурдвал, төсвийн санхүүжилттэй төслүүдэд цахим худалдан авах ажиллагааны систем нэвтрүүлсэн, төсвийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд урьдчилсан худалдан авах ажиллагааны зохицуулалтыг тусгаж оруулсан болон нээлттэй сонгон шалгаруулалтыг өргөнөөр ашигладаг болсон зэрэг байна. Хэдий дэвшил гарч байгаа ч Монгол Улс дахь худалдан авах ажиллагаатай холбоотой эрсдэл өндөр хэвээр байна.<sup>23</sup> Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүн халаа сэлгээ ихтэй, ажиллах хөшүүрэг сул, хангалттай сургалт хөгжүүлэлт хийгдэхгүй байгаа тул хорооны худалдан авах ажиллагааг зохион байгуулах чадвар сул байж, тендерийн талаарх үндэслэлтэй гомдлын тоо цөөрөхгүй байна. Гадаадын тендерт оролцогчдын талаар Засгийн газраас баримталж буй бодлого нь эрсдэлийн өөр нэгэн хүчин зүйл болдог, гэхдээ энэ нь АХБ-ны санхүүжилттэй төслүүдэд аливаа нөлөө үзүүлдэггүй болно. АХБ нь тулгарч буй эрсдэлийг удирдах зорилгоор худалдан авах ажиллагаанд хатуу хяналт тавих, чадавхыг бэхжүүлэх, худалдан авах ажиллагаанд урьдчилан болон дараа хянах горимыг ашиглах, засгийн газартай тогтмол ажиллаж, гадаадын тендерт оролцогчдод хамаарах бодлогын улмаас зах зээлийн нийлүүлэлтэд сөрөг нөлөө үүсгэхгүй байхад анхаарах зэргээр ажиллана.

59. **Засаглал.** АХБ-наас хийсэн засаглалын эрсдэлийн үнэлгээгээр нийтийн салбарын зөв зохистой үйл ажиллагаанд шаардагдах хууль эрх зүй ба тогтолцооны орчин үндсэндээ бүрэлдсэн ч хууль тогтоомжийн хэрэгжилт алаг цоог, практикийн ялгаа зөрүү байна гэж дүгнэсэн. Засгийн газрын хувьд гадаад нөхцөл байдал таагүй үед шинэтгэлд ач холбогдол өгч ажилладаг тул хөгжлийн түнш байгууллагууд цагаа олсон, зорилтот техникийн тусалцаа ба БСЗ-ийн дэмжлэг үзүүлэх боломжтой. АХБ-ны зүгээс арай цөөн тооны томоохон хөтөлбөрт төвлөрснөөр салбарын төлөвлөлтийг үйл ажиллагаандаа илүү гүнзгий суулгаж, бодлогын залгамж халаа болон салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх нөхцөл бүрэлдэж байна. Түүнчлэн, төрийн албан хаагчдын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх техникийн тусалцааг АХБ-наас үзүүлнэ.

60. **Уур амьсгал ба гамшигт тэсвэртэй байдал.** Монгол орны байгалийн зүй тогтоц нь агаарын хэмийн хэт савлалттай улирлын мөчлөг, салхи шуурга, ган гачиг, ой хээрийн түймэр, газар хөдлөлт ба зуданд<sup>24</sup> өртөмтгий зэрэг онцлогтой. Хүний үйл ажиллагаанаас улбаатай уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Монгол Улс цаг агаарын дулаарлын хурдаар дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд үүнтэй холбоотой байгалийн гамшигт үзэгдлийн далайц ба давтамж нэмэгдэж байна. АХБ-наас *Гамшгийн эрт дохиоллын цогц тогтолцоог бэхжүүлэх* төслийн<sup>25</sup> хүрээнд Монгол Улсын уур амьсгал ба гамшигт тэсвэртэй байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ гамшгийн онцгой байдлын санхүүжилтийн боломжуудыг судлах болно.

<sup>23</sup> Эрсдэлийн 4 шатлалд суурилсан (Нэн өндөр, Өндөр, Дунд, Бага).

<sup>24</sup> Зун нь ган гачигийн улмаас өвс ургамлын гарц муудаж, өвөл нь их хэмжээний цас (10-350 см) орж, салхи шууран, хэт хүйтрэхэд (-40°C-аас -50°C) зуд болдог.

<sup>25</sup> АХБ. 2020. Монгол улсад эрт сэрэмжлүүлгийн нэгдсэн системийг бэхжүүлэх. Манила.









## ТҮНШЛЭЛИЙН СТРАТЕГИЙН ҮР ДҮНГИЙН МАТРИЦ

### Засгийн газрын зорилтуудтай уялдсан байдал







<p><b>Улс орны зорилтууд<sup>а</sup></b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үндэсний ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь (2018: 28.4%; 2025 оны зорилт: 20%) (ТХЗ 1* ба 10**)</li> <li>2. Үндэсний түвшинд нэг жилд ялгарах хүлэмжийн хийн хэмжээ (CO<sub>2</sub>-н эквивалент, сая тонн) (2014: 34.5; 2030 оны зорилт: 57.4. [арга хэмжээ авахгүй үеийн үзүүлэлт буюу 74.3 сая тонныг 22.7% бууруулах]) (ТХЗ 13 ба 15**)</li> <li>3. Уул уурхайн бус ДНБ-ийн өсөлт (зэрэгцүүлэх үнээр) (2017-2020 оны дундаж: 4.7%; 2021-2024 оны зорилт: нэмэгдсэн байх) (ТХЗ 8**)</li> </ol>
<p><b>Үндэсний хөгжилд үзүүлэх үр нөлөө</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүмүүсийн аж амьдрал ба амьжиргаанд КОВИД-19 цар тахлын үзүүлсэн нөлөөлөл арилсан байх (ТХЗ 1, 2, 3 ба 5)</li> <li>2. Улаанбаатар хот дахь агаарын бохирдол буурсан байх (ТХЗ 11, 3)</li> <li>3. Жендэрийн тэгш байдал дорвитой сайжирсан байх (ТХЗ 5)</li> <li>4. Бүсийн даяарчлалд илүү өргөнөөр хамрагдаж, хэлхээ холбоо сайжирсан байх (ТХЗ 8, 9, 17)</li> </ol>

### АХБ-ны санхүүжилттэй хөтөлбөрийн үр дүн ба гүйцэтгэл

Тэргүүлэх чиглэл 1: Хүртээмжтэй нийгмийн хөгжил ба эдийн засгийн боломжуудыг хөхиүлэн дэмжинэ.	
Гол үр дүн	Үзүүлэлтүүд: (2024 оны зорилт: 80%-н гүйцэтгэл; Суурь үзүүлэлт: төслийн түвшинд бий болсон байна <sup>b</sup> )
1. КОВИД-19 цар тахлын үед хүмүүсийн аж амьдрал ба амьжиргаанад тусламж дэмжлэг үзүүлнэ.	 Нийгмийн хамгааллын өргөтгөсөн хөтөлбөрүүдээс өгөөж хүртсэн хүмүүс (хүлээгдэх үр дүн: 642,000) (ҮТЗ 1.1)
	 Хэрэгжилтийг нь дэмжсэн бизнесийн хөгжил ба санхүүгийн салбарын арга хэмжээ (хүлээгдэх үр дүн: 6) (ҮТЗ 1.2.1)
	 Эдийн засгийн болон бусад төрлийн гадаад цочролд тэсвэртэй байдал нь сайжирсан эмэгтэйчүүд (хүлээгдэх үр дүн: 122,000) (ҮТЗ 2.5)
2. Чанартай, эрх тэгш, хүртээмжтэй эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж сайжирна.	 Сайжруулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өгөөжийг хүртсэн иргэд (хүлээгдэх үр дүн: 2,178,000) (ҮТЗ 1.1)
	 Өндөр чанартай боловсрол ба сургалтад хамрагдсан иргэд (хүлээгдэх үр дүн: 4,200) (ҮТЗ1.1.1)
	 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний менежмент нь сайжирсан байгууллагын тоо (хүлээгдэх үр дүн: 2) (ҮТЗ 1.1.2)
3. Хөдөлмөрийн төвлөрөл ихтэй салбаруудад бичил, жижиг ба дүнд үйлдвэр, аж ахуйн нэгж ба Монгол иргэдэд нээлттэй эдийн засгийн боломжууд нэмэгдэнэ.	 Шинээр бий болсон ажлын байр (хүлээгдэх үр дүн: 2,000) (ҮТЗ 1.2)
	 Хөдөөгийн хөрөнгө оруулалтын өгөөжийг хүртсэн иргэд (хүлээгдэх үр дүн: 12,000) (ҮТЗ 5.1)
	 Зах зээлд гарах боломж нь сайжирсан фермер (хүлээгдэх үр дүн: 2,000) (ҮТЗ 5.2)
	 Фермерүүдийг үнэ цэнийн хэлхээнд үр ашигтайгаар холбосон агробизнес (хүлээгдэх үр дүн: 121) (ТЧ5.2.3)

<b>Эх үүсвэрүүд</b> Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр <sup>c</sup>	Засгийн газарт олгосон санхүүжилт	Хувийн хэвшилд олгосон санхүүжилт	Техникийн туслалцаа
	\$543 сая (20 төсөл)	\$62.1 сая (4 төсөл)	\$21.0 сая (31 ТТ төсөл)
Хэрэгжихээр хүлээгдэж буй төсөл хөтөлбөр <sup>d</sup>	Засгийн газарт олгох санхүүжилт (2021–2023)	Техникийн туслалцаа (2021–2023)	Мэдлэгийн бүтээгдэхүүн ба арга хэмжээ (2021)
	\$657 сая (11 төсөл)	\$14.8 сая (18 ТТ төсөл)	6
<b>Тэргүүлэх чиглэл 2: Өрсөлдөх чадвар ба эдийн засгийн төрөлжилтийг дэмжих уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлнэ.</b>			
<b>Гол үр дүн</b>	<b>Үзүүлэлтүүд</b>		
1. Хотын дэд бүтэц, суурь үйлчилгээний хамрах хүрээ ба чанар сайжирна	 Хотын нийтийн үйлчилгээ сайжирснаас өгөөж хүртсэн хүн (хүлээгдэх үр дүн: 238,000) (ҮТ34.1)		
	 Шинээр бий болсон эсвэл сайжирсан хотын дэд бүтцийн байгууламж (хүлээгдэх үр дүн: 10) (ҮТ34.1.2)		
	 Амьдрах орчин нь сайжирсан хотын бүс (хүлээгдэх үр дүн: 7) (ҮТ34.3) <sup>e</sup>		
	 Хотын орчинг сайжруулахаар хэрэгжүүлсэн шийдэл (хүлээгдэх үр дүн: 5) (ҮТ34.3.1)		
	 Уур амьсгал ба гамшигт тэсвэртэй байдал нь бэхэжсэн хүмүүс (хүлээгдэх үр дүн: 18,000) (ҮТ33.2)		
2. Аймаг хоорондын ба хил дамнасан хэлхээ холбооны үр өгөөж ба бүтээмж дээшилнэ	 Шинээр бий болгосон эсвэл сайжруулсан тээвэр, харилцаа холбооны байгууламжууд (хүлээгдэх үр дүн: 2) (ҮТ37.1.1)		
	 Хил дамнасан тээврийн ашигт ажиллагаа ба/эсвэл бүтээмжийг нэмэгдүүлэхээр хэрэгжүүлсэн арга хэмжээ (хүлээгдэх үр дүн: 3) (ҮТ37.1.2)		
<b>Эх үүсвэрүүд</b> Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр	Засгийн газарт олгосон санхүүжилт	Хувийн хэвшилд олгосон санхүүжилт	Техникийн туслалцаа
	\$218 сая (8 төсөл)	\$9.6 сая (1 төсөл)	\$4.6 сая (4 ТТ төсөл)
Хэрэгжихээр хүлээгдэж буй төсөл хөтөлбөр	Засгийн газарт олгох санхүүжилт (2021–2023)	Техникийн туслалцаа (2021–2023)	Мэдлэгийн бүтээгдэхүүн ба арга хэмжээ (2021)
	\$782.3 сая (7 төсөл)	\$17.3 сая (22 ТТ төсөл)	9
<b>Тэргүүлэх чиглэл 3: Ногоон бөгөөд уур амьсгалд зохицсон тогтвортой хөгжлийг цогцлооно.</b>			
<b>Гол үр дүн</b>	<b>Үзүүлэлтүүд</b>		
1. Дотоодын эх үүсвэрийн ашиглалт болон төсөв ба өрийн тогтвортой байдал сайжирна.	 Хувийн хэвшил ба санхүүгийн салбарыг дэмжих төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ (хүлээгдэх үр дүн: 10) (ҮТ36.1.2)		



		Тэсвэртэй байдлыг бэхжүүлж, эдийн засгийн цочролд цаг алдалгүй хариу арга хэмжээ авах чадварыг бүрдүүлэх үйл ажиллагаа (хүлээгдэх үр дүн: 4) (ҮТ36.1.3)		
2. Хүрээлэн буй орчны тогтвортой сайжирна		Жилийн нийт хүлэмжийн хийн ялгарлын бууралт (хүлээгдэх үр дүн: жилд 160,000 тонн нүүрстөрөгчийн давхар ислийн эквивалент) (ҮТ33.1)		
		Нүүрстөрөгчийн хамаарлыг бууруулах чиглэлээр дэмжлэг үзүүлж, хэрэгжүүлсэн шийдэл (хүлээгдэх үр дүн: 17) (ҮТ33.1.5)		
		Хүрээлэн буй орчны тогтвортой байдал (тухайлбал агаарын чанар ба хог хягадлын менежмент) сайжирснаас үр өгөөж хүртсэн хүн (хүлээгдэх үр дүн: 1,718,000) (ҮТ33.3)		
		Бохирдлын хяналт, нөөцийн үр ашигтай ашиглалтыг сайжруулахаар хэрэгжүүлсэн шийдлийн тоо (хүлээгдэх үр дүн: 9) (ҮТ33.3.2)		
		Газрын гарц нь сайжирсан талбай (га) (хүлээгдэх үр дүн: 3,000) (ҮТ35.3)		
<b>Эх үүсвэрүүд</b> Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр	Засгийн газарт олгосон санхүүжилт		Хувийн хэвшилд олгосон санхүүжилт	Техникийн туслалцаа
	\$438 сая (8 төсөл)		\$9.6 сая (1 төсөл)	\$10.7 сая (16 ТТ төсөл)
Хэрэгжихээр хүлээгдэж буй төсөл хөтөлбөр	Засгийн газарт олгох санхүүжилт (2021–2023)		Техникийн туслалцаа (2021–2023)	Мэдлэгийн бүтээгдэхүүн ба арга хэмжээ (2021)
	\$413.0 сая (6 төсөл)		\$13.9 сая (18 ТТ төсөл)	3

АХБ = Азийн Хөгжлийн Банк; КОВИД-19 = коронавирусууд үүсгэгдэх өвчин; МХТ=мэдээлэл, харилцааны технологи; ҮТЗ = Үйл ажиллагааны тэргүүлэх зорилт; ТХЗ = тогтвортой хөгжлийн зорилго; ТТ = техникийн туслалцаа.

<sup>a</sup> Тавьсан зорилтууд Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын Алсын хараа-2050, Засгийн газрын 2020-2024 оны Үйл ажиллагааны хөтөлбөр болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргасан Монгол Улсын Зорилтот хувь нэмэр зэрэг баримт бичигт суурилсан. \*Албан ёсны ТХЗ-ын үзүүлэлт. \*\*ТХЗ-той уялдсан үзүүлэлт \*\*\* Тогтоогдсон ТХЗ-г орлох үзүүлэлт.

<sup>b</sup> Үр дүн 80 хувийн гүйцэтгэлтэй байх буюу үйл ажиллагаа хэрэгжиж дуусахад нийт гүйцэтгэл нь төслийн баримт бичигт тодорхойлсон хүлээгдэх нийт үр дүнгийн 80 ба түүнээс дээш хувьтай тэнцүү байна. Хүлээгдэх үр дүн гэдэгт түншлэлийн стратегийн хугацаа дуусахаас өмнө (буюу одоогийн түншлэлийн стратегийн хэрэгжилтийн бэлтгэл жил, 1 дэх жил, 2 дахь жил, 3 дахь жилд) хаагдах үйл ажиллагааны үр дүнг ойлгоно. Жишээ нь: 2021-2024 оны түншлэлийн стратегид 2019-өөс 2022 оны хооронд санхүүжилт нь хаагдах үйл ажиллагаа байна. Төлөвлөсөн үр дүн бол гагцхүү тойм үзүүлэлт бөгөөд АХБ-ны төсөл хөтөлбөрийг түншлэлийн стратегийн эцсийн баталгаажилтаар үр дүнтэй хэрэгжсэн эсэхийг дүгнэхэд ашигладаг нарийвчилсан зорилтуудыг түншлэлийн стратегийн үед гаргах төслийн хаалтын тайлангуудад үндэслэн эцэслэнэ.

<sup>c</sup> Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн эх үүсвэр гэдэгт эх үүсвэр нь баталгаажсан техникийн туслалцааны (ТТ) санхүүжилтийг ойлгоно. Үйл ажиллагаа эсвэл ТТ-ны эх үүсвэрүүдийг тухайн үйл ажиллагаа эсвэл ТТ-тай уялдсан түншлэлийн стратегийн Зорилт тус бүрийн хэсэгт танилцуулсан, иймд нэг эх үүсвэрийг нэгээс олон түншлэлийн стратегийн Зорилтын хэсэгт танилцуулсан байж болно.

<sup>d</sup> Хэрэгжихээр хүлээгдэж буй төсөл хөтөлбөрийн эх үүсвэрийн хувьд Засгийн газарт олгох санхүүжилт ба ТТ-ны мэдээллийг 2021-2023 оны Үйл ажиллагааны хөтөлбөр ба Төсвийн хүрээ зэргээс авсан (АХБ, 2020). Үйл ажиллагааны хөтөлбөр ба Төсвийн хүрээ, 2021-2023), Засгийн газарт олгох санхүүжилт болон мэдлэгийн бүтээгдэхүүн ба арга хэмжээний эх үүсвэрийн хувьд 2021-2023 онд Улс оронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны

бизнес төлөвлөгөөнөөс авсан (АХБ, 2021. Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, 2021-2023).

° Бүс гэдэгт нийслэл Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн дүүрэг ба хороог ойлгоно.

## МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ МЭДЛЭГ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. **Хураангуй.** Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь 2017-2020 онд Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн хүрээнд мэдлэг шилжүүлэх үйл ажиллагаагаа ихээхэн тэлсэн бөгөөд 2021-2024 оны түншлэлийн стратегийн хүрээнд ч мөн хүчин чармайлтаа үргэлжлүүлсэн хэвээр байх болно. Мэдлэг шилжүүлэх үйл ажиллагаа нь Засгийн газрын болон түншлэлийн стратегийн тэргүүлэх чиглэлүүд, мөн АХБ-ны “Стратеги 2030”-тай нягт уялдсан.<sup>1</sup> АХБ нь мэдлэгт түшиглэсэн шийдлүүдийг боловсруулан (i) бодлогын зөвлөмж гаргах; (ii) хяналт ба үнэлгээг сайжруулж, хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шинэлэг аргуудыг нэвтрүүлэх замаар төсөл хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэх, (iii) төрийн сектор ба хувийн хэвшилд хамаарах үйл ажиллагааны хоорондох уялдаа холбоог бэхжүүлэх, (iv) харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн уян хатан төлөвлөлтийг хийх зорилго тавьсан. АХБ нь төрийн байгууллага, хөгжлийн түншүүд, иргэний нийгэм ба оролцогч бусад талтай мэдлэгийн түншлэлээ гүнзгийрүүлж, өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэн, дотооддоо мэдлэгийн шийдэл боловсруулах чадварыг хөгжүүлнэ. АХБ нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлага болон сургамжаа түгээн хуваалцахад анхаарлаа хандуулж, мэдлэгийн бүтээгдэхүүндээ үнэлгээ хийх сайжруулсан аргачлалаар бусдыг үлгэрлэн манлайлна.

### **А. Мэдлэг туршлагын хэрэгцээ**

2. АХБ-ны ач холбогдол зөвхөн санхүүжилт ба түншлэлээр зогсохгүй мэдлэгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд чухал байдгийг Стратеги 2030-д хүлээн зөвшөөрч, улс оронд хэрэгжүүлэх мэдлэгийн төлөвлөгөө (УМТ)-ний зөвлөмжийг гаргасан. Ийнхүү, АХБ-ны 2021-2025 оны Мэдлэг шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд төр ба хөгжлийн түншүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдлэгийн үйлчилгээний чанар ба үр өгөөжийг дээшлүүлэх, улс орны онцлогт тохирсон аргачлал ашиглан мэдлэгийн шийдэл боловсруулах ажлыг илүү үнэ цэнтэй болгохыг онцолсон.

3. АХБ-ны Монгол Улсад хэрэгжүүлдэг үйл ажиллагаанд мэдлэг шилжүүлэх чиглэл чухал байр суурь эзэлсээр ирсэн ба 2017-2020 оны түншлэлийн стратегийн хугацаанд үүнийг дахин шинэ шатанд гаргахаар төлөвлөсөн. Энэхүү ажлын үр дүнд агаарын чанар, эрүүл мэнд, боловсрол, тогтвортой аялал жуулчлал, хотын ногоон төлөвлөлт зэрэг чиглэлд төрөөс баримтлах бодлогыг чиглүүлсний зэрэгцээ санхүүгийн салбар, байгалийн баялгийн орлогын удирдлага ба жендэрийн тэгш байдлын асуудлаарх хууль тогтоомжийг сайхиулах төр ба иргэний нийгэмийн чадавхыг бэхжүүлж чадсан. Түүнчлэн, Монгол Улс Санхүүгийн арга хэмжээ авах ажлын хэсгийн саарал жагсаалтаас гарахад ихээхэн шаардлагатай байсан мэргэжлийн дэмжлэгээр хангаж, цахим шилжилт, Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдсан төсөв боловсруулалт, замын аюулгүй байдал зэрэг салбаруудад инновацийг нэвтрүүлэхэд Засгийн газарт туслалцаа үзүүлээд байна. Банкнаас улс оронд хэрэгжүүлэх мэдлэгийн төлөвлөгөө (УМТ)-г боловсруулсан ба үүнд одоо хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрөөсөө хуримтлуулсан мэдлэг туршлагаа судалгааны тайлан, олон нийт рүү чиглэсэн арга хэмжээгээр дамжуулан илүү идэвхтэй түгээхийг зорьсон. Банкнаас олгодог тусламж дэмжлэгийн бүтээгдэхүүн, модуль ба үйлчилгээний талаарх мэдээллийг илүү нээлттэй болгож, олон төрлийн арга хэмжээ болон хэвлэлээр түгээхийн зэрэгцээ АХБ-наас гаргадаг томоохон нийтлэл, бодлогын шинэ мэдээ, дүрэм журмын өөрчлөлт ба

<sup>1</sup> АХБ. 2018. Стратеги 2030: *Хөгжингүй, хүртээмжтэй, уян хатан, тогтвортой Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох нь*. Манила.

хэрэгжилтийн гарын авлагуудыг Монгол хэл рүү хөрвүүлээд байна.<sup>2</sup> Түүнчлэн, АХБ-ны үйл ажиллагааг танилцуулсан хэвлэл мэдээллийн аялал, сэтгүүлчид болон иргэний нийгмийн байгууллагуудад зориулж сурталчлах арга хэмжээнүүдийг<sup>3</sup> зохион байгуулсан бөгөөд видео бичлэгүүдийг бэлтгэсэн. АХБ-ны чухал ач холбогдол бүхий нийтлэлүүдийг нийтэд хүргэх зорилгоор тинктанк уулзалт, хөгжлийн түнш байгууллагуудын зөвлөгөөнийг зохион явуулж, Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улс дахь Суурин төлөөлөгчийн газрыг танилцуулах арга хэмжээг хийсэн. Эдгээр арга хэмжээний үеэр АХБ бусад оролцогч байгууллагад<sup>4</sup> танилцуулга, илтгэлүүдээ толилуулах нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн өргөн хэлэлцүүлэг өрнүүлэх чиг үүргээ хэрэгжүүлэхээр ажиллалаа. АХБ нь боловсруулсан мэдлэгийн бүтээгдэхүүн бодлогын эрэлт хэрэгцээнд нийцүүлэхийг чухалчиж, Монгол Улсад зориулан “Ажиглалт ба Санал” бодлогын цуврал тэмдэглэлүүдийг Англи, Монгол хэлээр гаргаж эхэлсэн бөгөөд түншлэлийн стратегийн хугацаа дуусахтай зэрэгцэн Монгол Улсад тулгамдаж буй хөгжлийн саад бэрхшээл ба ашиглаж болох боломжуудын талаарх бодлогын зөвлөмжийн эмхэтгэл гаргаад байна.<sup>5</sup> Энэхүү эмхэтгэл АХБ-ны 2021-2024 оны түншлэлийн стратегийг боловсруулах оношилгооны ажлын суурь болсон ба макро эдийн засгийн бодлого, байгалийн баялгийн орлогын удирдлага ба нийгмийн салбаруудад төрөөс баримтлах бодлогуудад ашиглах тодорхой зөвлөмжүүдийг агуулсан.

4. Дээрх үйл ажиллагаанд үндэслэн мэдлэгийн чиглэлийн хамтын ажиллагааг 2021-2024 онд Монгол Улсад хэрэгжүүлэх түншлэлийн стратегийн үндсэн хэсгийн нэг болгосон. АХБ-наас 2021-2025 оны Мэдлэг шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол Улсыг анхлан оруулсан ба энэхүү УМТ нь Засгийн газрын мэдлэгийн эрэлт хэрэгцээний судалгаа, өнөөгийн болон өмнөх үеийн мэдлэгийн бүтээгдэхүүн ба үйлчилгээний багцын нарийвчилсан дүн шинжилгээнд суурилсан. Дүн шинжилгээгээр мэдлэгийн бүтээгдэхүүний багц түншлэлийн стратегийн стратегийн чиглэлүүдтэй нягт уялдсаныг тогтоож, үйл ажиллагааны зардлыг бууруулахын тулд мэдлэг шилжүүлэх ба техникийн туслалцаа үзүүлэх төслүүдийн тоог цөөлөх бодит боломжуудыг тодорхойлов. АХБ нь үйл ажиллагаагаа Монгол Улсын хамгийн нарийн төвөгтэй, шийдвэрлэхэд хэцүү хөгжлийн сорилтуудад төвлөрүүлж, бодит үнэ цэнийг бүтээхэд анхаарах тухай түншлэлийн стратегид тодорхой тусгасан. Засгийн газар АХБ-наас мэдлэгийн дэмжлэг үргэлжлүүлэн авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн чиглэлүүдэд (i) хүртээмжтэй хөгжил, эдийн засгийн төрөлжилт, уул уурхайн салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг тэлэх; (ii) хувийн хэвшлийн хөгжил; (iii) төрийн институтын чадавх; (iv) эдийн засаг, хүн амын цочролд тэсвэртэй байдал; (v) уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ба хор уршгийг даван туулах зэрэг багтсан. АХБ нь УМТ-г хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны олон хэрэгсэл ба модулийг ашиглах болно. Энэхүү түншлэлийн стратегийн хугацаанд мэдлэгийн солилцоог дэмжих техникийн туслалцаа (МСТТ)-ны төслийн тоог цөөрүүлж, түншлэлийн стратегийн стратегийн чиглэл тус бүрийн мэдлэгийн үр дүнд бүрэн тусгагдсан, илүү стратегийн ач холбогдолтой, хөтөлбөрчилсэн мэдлэг ба ТТ төслүүд хэрэгжүүлэх тал дээр Засгийн

<sup>2</sup> Жишээ: АХБ. 2020. *Сургуулийн усны хангамж, ариун цэврийн байгууламж, эрүүл ахуйг сайжруулах нь: Монгол Улсын бодлого боловсруулагч болон бодлогын хэрэгжилтийг хангагчдын гарын авлага. Монгол хэл рүү хөрвүүлсэн хувилбар*. Манила. <https://www.AXB.org/mn/publications/improving-water-sanitation-hygiene-schools-mongolia>; ба АХБ. 2019. *Иргэний нийгмийн төвч танилцуулга: Монгол Улс. Монгол хэл рүү хөрвүүлсэн хувилбар*. Манила. <https://www.AXB.org/mn/publications/civil-society-brief-mongolia>

<sup>3</sup> Жишээ нь: [Монголын гэр хорооллуудын өдөр тутмын амьдралд шинэ дэд бүтэц гэрэл гэгээ авчирлаа](#); [Монгол Улсын дээд боловсролын салбарын шинэтгэл](#); [Монголын баруун бүсэд зам дагасан хөгжил айсу](#); [Шинэ технологи Монголын хөдөөг дэлхийн түвшний эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холболоо](#).

<sup>4</sup> IRIM Судалгааны хүрээлэн. 2019. “Монголын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”; ба СИКА. 2020. *Монголын нийгмийн үеийг тодорхойлох судалгаа*.

<sup>5</sup> АХБ. 2020. *Монгол Улсын эдийн засгийн хэтийн төлөв: Хоёр том гүрний дунд орших арвин баялаг бүхий орон*.

газартай тохироод байна. АХБ-наас МСТТ-ны төлөвлөлт ба төслийн хүрээнд хийгдэх хяналт үнэлгээг сайжруулах замаар өмнөх үеийн сургамжуудыг одоогийн үйл ажиллагаандаа тусгаж, шинэ мэдлэг туршлага хуримтлуулан, цаашид олон нийтэд түгээхэд анхаарна. Засгийн газраас тавьсан хүсэлтийн дагуу АХБ нь “Ажиглалт ба Санал” цувралаа үргэлжлүүлэн гаргах бөгөөд мэдлэгийн бүтээгдэхүүнүүд нь олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэн, мэдлэгийн шийдэл хайх эрэлтийг бий болгохын зэрэгцээ тус улсын бодлогод нийцсэн байхад анхаарна.

## **Б. АХБ-ны мэдлэг солилцох үйл ажиллагааны хамрах хүрээ**

5. АХБ-ны мэдлэгт суурилсан шийдлүүд нь энэхүү түншлэлийн стратегийн үндсэн зорилго буюу Монгол Улс КОВИД-19 цар тахлын хямралыг даван туулах, цаашлаад урт хугацаанд тогтвортой, хүртээмжтэй хөгжлийн суурийг тавихад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ. Стратегийн тэргүүлэх чиглэл 1 (хүртээмжтэй нийгмийн хөгжил ба эдийн засгийн боломжуудыг хөхиүлэн дэмжих)-ийн хүрээнд АХБ нь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын төлөвлөлтийг бэхжүүлж, санхүүжилтийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарын хяналт зохицуулалтыг чанаржуулах, бизнесийн зөвлөх үйлчилгээгээр дамжуулан бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагаагаа тэлэх боломжуудыг нээх зэргээр бизнесийн орчны шинэчлэлийг эрчимжүүлэхэд анхаарна. Стратегийн тэргүүлэх чиглэл 2 (өрсөлдөх чадвар, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих уур амьсгалд тэсвэртэй дэд бүтцийг хөгжүүлэх)-ын хүрээнд АХБ авто замын аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийн засвар үйлчилгээ болон логистикийн үйл ажиллагааг сайжруулах, уул уурхайн салбарт нэмүү үнэ цэнийг бүтээх, хот төлөвлөлтийг дэмжих ба худалдааны бодлогыг бэхжүүлэх зэрэг зорилгуудыг тодорхойлсон. Стратегийн тэргүүлэх чиглэл 3 (ногоон бөгөөд уур амьсгалд зохицсон тогтвортой хөгжлийг цогцлоох)-ын хүрээнд хэрэгжих АХБ-ны үйл ажиллагаа гадаадын шууд хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах, татварын шинэчлэлийг эрчимжүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, байгаль орчны менежментийг сайжруулах, хүн амын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох байдлыг бэхжүүлэх, тогтвортой агробизнесийн үнэ цэнийн хэлхээг хөгжүүлэх зэрэгт төвлөрнө. Стратегийн чиглэл бүрд АХБ-ны үйл ажиллагааны үр нөлөөг гүнзгийрүүлэх мэдлэгийн шийдэл агуулагдах хэдий ч мэдлэг солилцох хамтын ажиллагаа ба шийдлүүдийг түншлэлийн стратегийн сэдэвчилсэн чиглэлүүдэд мөн суулгах бөгөөд үүнд жендэрийн тэгш байдлыг хангахад гарч буй ахиц дэвшлийг эрчимжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо ба хөгжлийг хөхиүлэн дэмжих, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, цахим шилжилтийг дэмжих, институцийн чадавх ба засаглалыг бэхжүүлэх зэрэг чиглэлүүд багтсан.

6. АХБ нь мэдлэгийн бүтээгдэхүүн ба үйлчилгээнийхээ уян хатан байдалд онцгой анхаарах шаардлагатай. Учир нь Засгийн газраас АХБ-ийг хөгжлийн хамгийн том түншийн хувьд эрэлт хэрэгцээнд нь нийцүүлэн ажиллах чадвартай гэсэн хүлээлттэй байдгаас гадна, Монгол Улсын нөхцөл байдалд тодорхой бус хүчин зүйл цөөнгүй бөгөөд мэдлэг солилцох үйл ажиллагаа нь өөрчлөлтийг даган зохицох шаардлагатай байдаг. АХБ нь жил бүрийн төсөл хөтөлбөрийн төлөвлөлт болон хэрэгжилтийн үнэлгээ хийх ажлынхаа хүрээнд мэдлэг солилцох үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлох ажлаа үргэлжлүүлэхдээ тэдгээрийг түншлэлийн стратегийн стратегийн чиглэлүүдтэй уялдуулж, банкны одоогийн үйл ажиллагаанд хамруулна. АХБ-наас зээлийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоход чиглэсэн, өмнөх үеийн мэдлэгийн бүтээгдэхүүн ба үйлчилгээнд суурилсан, хувийн хэвшлийн үйл ажиллагааны шинэ боломжуудыг нээсэн, Засгийн газрын бодлого тодорхойлох ажилд шууд ач холбогдолтой мэдлэгийн шийдлүүдэд онцгой ач холбогдол өгөх болно. Хараат бус үнэлгээний газраас санал болгосноор, АХБ-наас өөрийн төсөл хөтөлбөр, техникийн тусалцаандаа илүү шинэлэг, мэдлэгт суурилсан шийдлүүдийг

нэвтрүүлэх замаар үйл ажиллагааныхаа нэмүү үнэ цэнийг бий болгохыг зорьж ажиллана. АХБ-ны мэдлэг солилцох үйл ажиллагаанд институцийн болон чадавхи бэхжүүлэх ажиллагаа томоохон байр суурийг эзлэх болно. МСТТ-ны хөтөлбөрөөрөө дамжуулан АХБ эрүүл мэнд, боловсрол зэрэг салбарт өртөг зардлаа төсөвлөсөн урт хугацааны ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг дэмжих бөгөөд бусад салбарт ийм туслалцаа үзүүлэх боломжийг эрэлхийлнэ.

## **В. “Нэг АХБ” аргачлалын хүрээнд мэдлэгийг дэмжих арга шийдэл**

7. АХБ-ны Зүүн Азийн Газар (ЗАГ), Хувийн хэвшлийн үйл ажиллагааны газар болон Төр-хувийн хэвшлийн түншлэлийн газраас Эдийн засгийн судалгаа ба бүсийн хамтын ажиллагааны газар, Тогтвортой хөгжил ба уур амьсгалын өөрчлөлтийн газартай хамтран УМТ-г боловсруулсан. ЗАГ нь Мэдлэг солилцооны үйл ажиллагааны төлөвлөгөөний замын зураглалыг боловсруулах бөгөөд түүнийгээ АХБ доторх үйл ажиллагааг уялдуулан, Нэг АХБ аргачлалыг таниулан сурталчлах талбар болгон ашиглана. Монгол Улс дахь мэдлэг солилцооны үйл ажиллагааг АХБ-ны Монгол Улс дахь Суурин төлөөлөгч хариуцан ажиллаж, мэдлэгийн шийдлүүд Засгийн газар ба АХБ-ны зорилтуудтай уялдсан эсэхийг нь нягталж, нарийн шалгуураар сонгон эрэмбэлнэ. Суурин төлөөлөгчийн газрын тэргүүлэх эдийн засагч болон гадаад харилцааны мэргэжилтэн нар мэдлэг солилцох үйл ажиллагааны зохицуулагчийн үүргийг гүйцэтгэж, МСТГ болон АХБ-ны бусад газар хэлтсийг холбон ажиллана.

8. Монгол дахь зохицуулагчид хэрэгжиж буй төсөл хөтөлбөрөөс мэдлэг мэдээлэл цуглуулахад онцгой анхаарч, нэн ялангуяа төслийн хэрэгжилтээс үнэтэй сургамж хуримтлуулахыг чухалчилна. ЗАГ нь Монгол Улсад мэдлэгийг хуримтлуулж, түгээхдээ АХБ-ны голлох тайлан, мэдлэгийн бүтээгдэхүүнүүдийг ашиглана. Монгол Улсад 2022-2024 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд ирэх жил бэлтгэн гаргах мэдлэгийн бүтээгдэхүүн болон үйлчилгээг танилцуулсан. АХБ нь түншлэлийн стратегийг хэрэгжүүлэх хугацаандаа шаардлагатай тохиолдолд мэдлэгийн солилцоог дэмжих олон салбарын мэргэжилтнүүдийн багийг бүрдүүлэн ажиллах бөгөөд ЗАГ-аас “Нэг АХБ” аргачлалын дагуу бусад газар хэлтэстэй нягт хамтран ажиллаж, хэрэгцээтэй мэдлэг туршлагыг татан төвлөрүүлнэ.

## **Г. Хөгжлийн бусад түнш байгууллагатай хамтран ажиллах чиглэл**

9. АХБ нь хөгжлийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд болон засгийн газартай уялдаа холбоотой ажиллаж, мэдлэгийн бүтээгдэхүүн хамтран боловсруулах боломжуудыг эрэлхийлэн, Монгол Улс дотооддоо мэдлэгийн чадавх ба түншлэлүүдийг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ. АХБ-ны мэдлэг солилцох үйл ажиллагаа нь хөгжлийн бусад түнш байгууллага болох Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон Дэлхийн банкны ижил төстэй үйл ажиллагааг нөхөн баяжуулахад чиглэдэг. Банкнаас төр-хөгжлийн түнш хоорондын үйл ажиллагааг уялдуулах механизмуудаар дамжуулах, Олон улсын валютын сангаас Монгол Улсад тогтмол ирж ажилладаг багийн бүрэлдэхүүнд орох зэргээр бодлогын хэлэлцүүлгийг манлайлж макро эдийн засгийн бодлогын шинэтгэлийн ажилд нягт оролцсон хэвээр байх болно. АХБ нь мэдлэг түгээх үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор эрдэмтэн судлаачид, хэвлэл мэдээлэл, судалгаа шинжилгээний байгууллагууд болон мэргэжлийн холбоод зэрэг иргэний нийгмийн төлөөлөлтэй хийх хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж, Засгийн газрын мэдлэг шилжүүлэх эрэлт хэрэгцээнд цаг ямагт уялдуулна. Ингэхдээ Монгол дахь Суурийн төлөөлөгчийн газраас 2019 онд байгуулсан Иргэний нийгэмтэй зөвлөлдөх хороо, Азийн Сантай хамтран хийдэг улс төр-эдийн засгийн дүн шинжилгээ гэх мэт мэдлэг солилцох стратегийн түншлэл

болон тогтмол зохион байгуулдаг тинк-танктай хийх уулзалтууд, иргэний нийгэм болон хэвлэл мэдээллийн байгууллагуудад зориулсан сургалт, уулзалт зөвлөгөөнүүдээр дамжуулан хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх болно.<sup>6</sup> Түншлэлийн стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэхдээ Төв Азийн Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээлэн зэрэг бүсийн хамтын ажиллагаа, мэдлэг солилцох сувгуудаас мэдлэгт суурилсан шийдлүүдийг дайчлан ажиллах болно. АХБ нь хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж, бусад олон талт хөгжлийн банкуудын хамтаар төр ба хувийн хэвшил хоорондын мэдлэгийн хэлэлцүүлгийг бэхжүүлэх боломжуудыг эрэлхийлнэ.

#### **Д. Эх үүсвэрийн хуваарилалт**

10. Мэдлэгийн бүтээгдэхүүн болон үйлчилгээг санхүүжүүлэх эх үүсвэрийг түншлэлийн стратегид танилцуулсан үндсэн эх үүсвэрээс гаргана. Түүнчлэн, мэдлэгийн бүтээгдэхүүнийг дэмжих хамтарсан санхүүжилтийн боломжуудыг эрэлхийлж, бүсийн ТТ-ны төслүүдийн үйл ажиллагааг уялдуулах замаар болон АХБ-ны Хүрээлэнтэй хамтран ажиллаж, боломжит бусад эх үүсвэрүүдийг дайчлах болно. АХБ-наас Монгол Улсад хэрэгжүүлэх мэдлэгийн үйл ажиллагааны хяналт ба үнэлгээг жил бүрийн төсөл хөтөлбөрийн төлөвлөлтийн болон хэрэгжилтийн үнэлгээтэй уялдуулан хийхийн хажуугаар төсөл хөтөлбөр, ТТ тус бүрийн хэрэгжилтийг үнэлэх ажлын хүрээнд хийнэ.

---

<sup>6</sup> Жишээ нь: Иргэний нийгмийн байгууллагуудтай жил бүр хийдэг уулзалт семинар, ИНБ-тай салбарын асуудлаар зөвшилцөх уулзалтууд, АХБ-ны төслүүдийг хэвлэл мэдээллийн төлөөлөлд танилцуулах аяллууд, Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клубтэй хамтран зохион байгуулдаг арга хэмжээнүүд.

**ХОЛБООСООР ХАВСАРГАХ БАРИМТЫН ЖАГСААЛТ**  
<http://www.adb.org/Documents/CPS/?id=MON-2021>

1. Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ
2. Хөгжлийн дэмжлэгийн уялдаа, зохицуулалтын матриц